


МАНДАЛ
даатгал

ЖИЛИЙН ТАЙЛАН 2018



АГУУЛГА

- 05 МАНДАЛЫН ТОЙМ
- 18 МАНДАЛЫН БИЗНЕС
- 29 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ФУНКЦҮУД
- 49 МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ
- 61 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Мандал Даатгал ХК

2018

ЖИЛИЙН ТАЙЛАН




МАНДАЛЫН ТОЙМ



2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мандал даатгал нь 2018 онд Монголын даатгалын салбарын анхны хувьцаат компани боллоо.

ЦЭВЭР АШИГ, сая төгрөг



 **251** хувийн өсөлт

ДААТГУУЛАГЧИЙН ТОО



 **66** хувийн өсөлт

ХУРААМЖИЙН ОРЛОГО, сая төгрөг




 **23** хувийн өсөлт

НИЙТ ХӨРӨНГӨ, сая төгрөг



 **57** хувийн өсөлт

МӨНГӨН ХӨРӨНГӨ, сая төгрөг



 **108** хувийн өсөлт

НИЙЛМЭЛ ХАРЬЦАА*



* Нийлмэл харьцаа: Үйл ажиллагааны зардал болон цэвэр нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцдог үзүүлэлт.

Мандал даатгал нь 2018 онд өсөлтийн хурдаа хадгалж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх стратегийг баримтлан ажилласны үр дүнд санхүүгийн голлох үзүүлэлтүүдээр салбартаа манлайлан, **даатгалын салбарын тэргүүлэх компани** боллоо.

2018 оны онцлох үйл явдал:

- 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн төлөвлөгөөгөө 2 дахин давуулан биелүүллээ. Тайлант хугацаанд хураамжийн орлого 23 хувиар, үйл ажиллагааны зардал харьцангуй бага буюу 15 хувиар өссөн байна.
- 2018 оны 9-р сард Монголын хөрөнгийн биржээр ("МХБ") дамжуулан IPO хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25 хувийг эзэмшүүлэн, 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт татсанаар нээлттэй хувьцаат компани боллоо. Мандал даатгалын хувьцаа МХБ-ийн I ангилалд багтсан бөгөөд 2019 оны ТОП 20 индексэд орлоо.
- Эрүүл мэндийн даатгалаар даатгуулагчдын тоо 2 дахин өссөн бөгөөд хувийн эрүүл мэндийн даатгалын зах зээлийн 60 хувийг дангаараа бүрдүүлж байна.
- БНСУ-ын Сөүл хотын Ионсей нэгдсэн эмнэлэг, SM гэмтлийн эмнэлэг, Даэгү хотын Кёонбугдэ нэгдсэн эмнэлэг, W гэмтлийн эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулснаар харилцагчид маань тухайн эмнэлгүүдээр үйлчлүүлэх боломж бүрдлээ.
- Байгууллагын хэмжээнд ажилтнуудын ашиглаж байгаа программ хангамжуудыг лицензжүүлж, "Microsoft office 365" шийдлийг нэвтрүүлснээр мэдээллийн аюулгүй байдлын түвшин нэг шат ахилаа.
- 2018 оны 10-р сард шинэ оффист нүүн орсноор харилцагчдадаа илүү ойртон, ая тухтай орчинд үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүллээ.

МОНГОЛЫН ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад даатгалын салбар үүсч хөгжөөд 83 жил болж байгаа хэдий ч арилжааны даатгалын хэлбэрт шилжээд ердөө 28 жил болж байгаа, хөгжлийн хувьд гарааны шатандаа байгаа шинэ салбар билээ.

Даатгалын салбар нь Монгол Улсын санхүүгийн секторын 1 хувийг эзэлдэг. Даатгалын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь буюу даатгалын нэвтрэлтийн түвшин ердөө 0.5 хувь байна. Энэ үзүүлэлтийн дэлхийн дундаж нь 6.1 хувь, харин хөгжиж буй орнуудад 3.3 хувь тус тус байдаг байна.

Даатгалын салбарын голлох үзүүлэлтүүд

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг



НИЙТ ХӨРӨНГӨ, тэрбум төгрөг



НЭВЧИЛТИЙН ТҮВШИН (ХО/ДНБ), хувиар



НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР тэрбум төгрөг



Санхүүгийн зохицуулах хорооноос ердийн даатгалын 17 хэлбэрийг баталсан бөгөөд голлох 5 бүтээгдэхүүн салбарын нийт хураамжийн орлогын 82 хувийг бүрдүүлж байна.



ДААТГАЛЫН САЛБАРЫН ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА, БОЛОМЖ

Нэг талаас даатгалын салбарын хөгжил доогуур байгаа хэдий ч нөгөө талаас ирээдүйд өсч хөгжих асар их боломжтой салбар юм. Монгол Улс 2012 оноос “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал” хэрэгжүүлж эхэлсэн нь салбарын хөгжилд томоохон түлхэц болсон төдийгүй иргэд даатгалын ач холбогдлыг ойлгож, мэдрэх нэг алхам боллоо.

Даатгалын нэвтрэлтийн түвшин хөгжиж буй орнуудын хэмжээнд хүрэхэд өнөөгийн түвшнээс 10 дахин өсөх боломж байна. Энэхүү өсөлтийг хангах, салбарт бий болж буй зарим илэрхийллээс онцлон дурдвал:

- Америк, Европын орнуудад банкны болон даатгалын салбар адил түвшинд хөгжсөнөөр эдийн засгийн тогтвортой өсөлт нь хангагддаг. Монгол Улсын санхүүгийн зах зээлд банкны салбар дангаар давамгайлж, даатгалын салбар ердөө 1 хувийг эзэлж байгаа ч төрийн байгууллагуудаас даатгалын салбарын хөгжилд ихээхэн ач холбогдолтой хандаж байна. 2017 онд батлагдсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүгийн зах зээлд даатгалын эзлэх хувийг өсгөх зорилт дэвшүүлжээ.
- 2018 онд Монгол Улсад 585,363 тээврийн хэрэгсэл зам тээврийн хөдөлгөөнд оролцож, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 100 хувь хамрагдсан байна. Харин 100,628 тээврийн хэрэгсэл даатгуулж, 28.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Хэрэв тээврийн хэрэгслийн даатгалын нэвтрэлтийн түвшин 50 хувьд хүрвэл салбарын хураамжийн орлого 54 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.
- 2015 онд Мандал даатгал Монголын анхны хувийн, эрүүл мэндийн “Жаргалан” даатгалыг хөгжүүлэн зах зээлд нэвтрүүлжээ. “Жаргалан” даатгал 2018 оны байдлаар хувийн эрүүл мэндийн даатгалын зах зээлийн 60 хувийг эзэлж байна. Монгол Улсын 3,2 сая иргэний 50 хувь нь хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдвал, хураамжийн орлого 850 тэрбум төгрөгт хүрч өсөх боломжтой юм.
- Даатгалын зах зээл хөгжсөн орнуудад банкууд бүх зээлээ даатгалд хамруулж, эрсдэлээ шилжүүлдэг. 2018 оны эцсээр Монголын банкны салбарт 1.2 сая зээлдэгч 17.1 их наяд төгрөгийн зээлийн багцтай байгаагаас бизнесийн зээлийн барьцаа хөрөнгийн дийлэнх нь даатгалд хамрагдаагүй байна.
- Мандал даатгал нь 2012 онд Хаан банктай хамтран, Монгол Улсад банкны зуучлалыг эхлүүлсэн туршлагатай. 2018 онд даатгалын салбарт 26.5 тэрбум төгрөгийн хураамж банкны зуучлалаар дамжин төвлөрсний 22 хувийг Мандал даатгал эзэлж байна. Бидний тооцоогоор ирэх 3 жилд банкны бүх зээл даатгалтай болох бөгөөд салбарын хураамжийн орлогод эрс өөрчлөлт гарахаар байна.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын даатгалын талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд байнга анхаарч, тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйлчилгээгээ тасралтгүй сайжруулахын зэрэгцээ даатгалын бүтээгдэхүүнийг хялбархан шийдлээр худалдан авах боломжийг нь хангахын тулд технологийн дэвшлийг ашиглах шаардлагатай байна.

Орчин үед санхүүгийн үйлчилгээг гар утас, ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан, илүү хялбар хүртээмжтэй байдлаар хүргэж байна. Олон улсад даатгалын үйлчилгээ нь технологийн давуу талыг ашигласан харилцагч төвтэй загвар луу хөгжиж байна. Иймд дотоодын даатгалын компаниуд ч мөн адил дэлхий нийтийн хөгжилд хөл нийлүүлэн, шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай.

УДИРДЛАГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хөрөнгө оруулагчид Монголын даатгалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, зах зээлд өөрийн байр суурийг аль хэдийн эзэлсэн, өндөр өсөлттэй компанийн эзэн болох замаар даатгалын салбарын үр шимийг хүртэх боломж нээгдсэн.

ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,

Би та бүгддээ компанийнхаа гол амжилтуудыг тоймлон хүргэхийн ялдамд, компанийн өмнө буй боломжуудын талаарх өөрийн бодлыг хуваалцахыг хүсч байна.

Мандал даатгал 2018 онд 27,8 тэрбум төгрөгийн орлого, 3,9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтайгаар ажиллаж, нийт хөрөнгийн хэмжээгээ 33,8 тэрбум төгрөгт хүргэлээ. Даатгуулагчдын тоо 66 хувиар есч 71 мянган хүрсэн ба компанийн дансанд буй бэлэн мөнгөний хэмжээ 22,9 тэрбум төгрөг болон нэмэгдсэн байна. Бид цэвэр ашиг, бэлэн мөнгөний нөөцөөрөө даатгалын салбарыг тэргүүлж байна.

Бид 2018 оны 9-р сард хувьцаагаа олон нийтэд гаргаж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалснаар хөрөнгийн зах зээл дээр хоёр шинэ үзэгдлийг бий болгосон гэж үзэж байна. Нэгдүгээрт, бид даатгалын салбарын тэргүүлэгч компаниудаас анхны олон нийтэд нээлттэй компани боллоо. Ингэснээр хөрөнгө оруулагчид Монголын даатгалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, зах зээлд өөрийн байр суурийг аль хэдийн эзэлсэн, өндөр өсөлттэй компанийн эзэн болох замаар даатгалын салбарын үр шимийг хүртэх боломж нээгдсэн юм. Хоёрдугаарт, компанийг нээлттэй болгосны дараа ямарваа нэг нэгдмэл сонирхолтой этгээд компанийн нийт хувьцааны 51-ээс дээш хувийг эзэмшихгүй байгаа тул хөрөнгийн зах зээл дээр корпорацийн засаглал сонгодог утгаар хөгжих анхны жишээг бий болгож байна.

Цаашид бид даатгалын зах зээлийн нэр хүндийг хөрөнгийн зах дээр өндөрт өргөж явах, хувьцаат компанийн корпорацийн засаглалын жишгийг тогтоох хариуцлагатай үүргийг хүлээн авч байна.

Бид нэгэнт нээлттэй компани болж, хувьцааны маань ханш хөрөнгийн зах дээр чөлөөтэй тогтоогддог болсон тул энэ талаар бас ярих нь зүйтэй. Хөрөнгийн захад оролцогч нарыг үндсэнд нь хоёр ангилж болно. Эхнийх нь богино хугацааны ханшийн хөдөлгөөнөөс ашиг олох зорилготой спекуляторууд. Удаах нь урт хугацаанд хөрөнгө оруулагч нар юм. Спекуляторууд компанийн санхүүгийн үзүүлэлтүүд, зах зээлийн боломжийг харахаасаа илүүтэйгээр богино хугацааны мэдээлэл, хөрөнгө оруулагч нарын сэтгэл хөдлөлийг дагуулан арилжаа хийдэг. Харин урт хугацааны хөрөнгө оруулагч нар компанийн ирээдүйг 5, 10 жилээр харж, зах зээлийнх нь нөхцөл байдлыг ойлгож, санхүүгийн хүчин чадлыг нь судалж байж хөрөнгө оруулдаг.

Миний хувьд дилер мэргэжлийг эзэмшээд, олон улсын санхүүгийн зах дээр арилжаа хийх явцдаа аливаа хөрөнгө оруулалтын хэрэгслийн ханш нь урт хугацаанд заавал түүний бодит үнэ цэнэ рүү дөхдөг болохыг мэдсэн юм. Өөрөөр хэлбэл спекуляторууд ханшийг хөөрөгдөх, эсвэл унагааж болно. Тэд ханшийн их хэмжээний савлагаа ч үүсгэж мэднэ. Гэхдээ эцсийн мөчид бирж дээрх үнэ тухайн компанийн бодит үнэлгээнд дөхөж очдог гэсэн үг. Энэ утгаараа богино хугацаанд спекуляторууд илүү сүйхээтэй мэт харагддаг боловч, өнөөдөр дэлхийн хамгийн амжилттай хөрөнгө оруулалтын сангууд, хамгийн баян хөрөнгө оруулагч нар дандаа урт хугацааны хөрөнгө оруулагч нар байдаг гайхах зүйл үгүй.

Урт хугацааны хөрөнгө оруулагч нар компаниудын бирж дээрх үнийг компанийн үнэлгээтэй нь харьцуулж заавал үздэг. Би та бүгдэд жишээ болгож дараах хүснэгтээр үзүүлээ.

Компани	P/E
Мандал Даатгал ХК	8.5
АПУ ХК	11.4
Говь ХК	14.7
Ард Даатгал ХК	15.2
Лэндмн ХК	22.2

Энэ хүснэгтээс та Монголын хөрөнгийн бирж дээрх том компаниудаас Мандал даатгал хамгийн хямд үнэлэгдсэн байгааг харж болно. Зарим хувьцаа эзэмшигч нар надаас “Компанийн хувьцааны ханшийг өсгөх арга хэмжээ авахгүй юу?” гэж асууж байсан. Тэгэхээр миний өмнө хэлсэнчлэн хөрөнгийн зах дээр үйлчилдэг зүй тогтлын дагуу хэт өндөр байгаа компаниудын хувьцааны ханш бодит үнэлгээтэйгээ ойролцоо түвшин хүртэл унаж, харин хямдаар тогтоогдсон компаниудын хувьцааны ханш өсөх болно. Өөрөөр хэлбэл урт хугацаанд Мандал даатгалын хувьцааны ханш тасралтгүй өснө гэж би харж байна.

Эцэст нь би даатгалын зах зээлийн боломжийн талаарх өөрийн бодлуудаас хуваалцъя.

2018 оны эцсээр банкны салбарын нийт актив 30 их наяд төгрөгт хүрч улсын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцэж ирсэн байна. Энэ нь банкны салбарын өсөлт ханаж байгааг харуулах юм. Одооноос эхлээд банкнууд шинэ зах зээлд нэвтрэх гэхээсээ илүүтэй, одоо байгаа зах зээлээ булаалдах шинэ өрсөлдөөний динамикт шилжих болно.

Гэтэл жам ёсоороо банкны салбартай эн зэрэгцэн оршдог даатгалын салбарын маань нийт актив ердөө 331 тэрбум төгрөг байгаа нь энэ салбарын өмнө ямар их шинэ зах зээл байгааг харуулна. Монгол улсад хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, амь насаа даатгуулаагүй, хөрөнгөө даатгуулаагүй хэчнээн хүн, хэчнээн компаниуд байгаа билээ. Цаашид тэнцвэртэй санхүүгийн зах зээлийг хөгжүүлж гэвэл заавал даатгалын салбарыг төрөөс анхаарч хөгжүүлэхээс өөр аргагүй. Ийм учраас даатгалын салбарын хөгжлийг хангасан хэд хэдэн шинэ хуулиуд ойрын жилүүдэд батлагдан гарах болов уу. Мөн сүүлийн жилүүдэд зах зээл, эдийн засаг, эрсдэлийн талаар илүү давамгайл мэдлэгтэй хүн амын шинэ үе ажил, амьдралын талбарт гарч ирсэн нь даатгалын салбарт ирээдүйн олон тооны харилцагч нарыг бий болгон өгч байна.



Ө.Ганзориг
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

ЭРХЭМ ХҮНДЭТ ХАРИЛЦАГЧИД, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,

Мандал даатгал нь анх 2011 онд үүсгэн байгуулагдаж, даатгалын салбарт шинэ өнгө нэмсэн. Үүсгэн байгуулагдсан эхний 5 жилд бид зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажилласан бөгөөд үүний үр дүнд 2016 онд даатгалын салбарын ТОП 3 компанийн нэг болж чадсан билээ.

2017 онд бид бизнесийн стратегиа “Зах зээлд эзлэх байр сууриа хадгалан, илүү чанартай бизнес хийх” гэж шинэчлэн тодорхойлсон юм. Чанартай бизнес гэдэг нь сэтгэл ханамжтай үйлчилгээ, мэргэжлийн, чадварлаг хамт олон, ашигт ажиллагаа гэсэн үндсэн 3 үзүүлэлтээр илэрхийлэгдэх ба энэхүү стратегийг хэрэгжүүлэхийн тулд компанийн хэмжээнд дэс дараатай олон ажлууд хийгдсэн билээ. Үүний үр дүнд Мандал даатгал 2017 онд 1.1 тэрбум, 2018 онд 3.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан амжилттай байна.

2019 болон ирэх онуудад бид бүтээмжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, тухайлчилбал нөхөн төлбөр олгох хурдыг эрс нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болно. Мөн даатгалын салбарын хамгийн том компани болсны хувьд олон нийтэд даатгал, эрсдэлийн талаар зөв ойлголтыг түгээх, өнөөгийн эрсдэлтэй нийгэмд амьдарч буй иргэдийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, даатгалын зах зээл, цаашлаад хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, тэлэх зэрэгт үүрэг, хариуцлагаа ухамсарлан, түүчээлэн оролцох болно.

Мандалд хөрөнгө оруулсан, биднийг өөрийн эрсдэлийн удирдлагын зөвлөхөөр сонгосон харилцагчид болон хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлэхийн ялдамд, та бүхэнтэй бид илүү нягт хамтран ажиллаж, та бүхний хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлэн ажиллахаа амлаж байна.

Бид бүхний харилцан ашигтай хамтын ажиллагаа урт удаан хугацаанд үргэлжилнэ гэдэгт бид цаг ямагт итгэдэг.



Б.Жавхлан
Гүйцэтгэх захирал

МАНДАЛЫН АЛСЫН ХАРАА ЭРХЭМ ЗОРИЛГО

Мандал Даатгал компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс нь бидний хийж буй ажил, гаргаж буй шийдвэр бүрийн суурь нь болдог.



АЛСЫН ХАРАА

Азийн тавцанд өрсөлдөх даатгал, санхүүгийн олон улсын брэндийг бий болгох

Мандал даатгал үүсгэн байгуулагдсанаасаа хойш харьцангуй богино хугацаанд салбартаа тэргүүлэгч даатгалын компани болсон төдийгүй Мандал даатгалын алсан хараа бол зөвхөн Монголын шилдэг даатгалын компани болсноор хязгаарлагдахгүй, Азийн орнуудын зах зээлд гарч өрсөлдөх монгол брэндийг бий болгох явдал юм.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Өнөөдрөө баталгаажуулсан маргаашийг иргэн бүрд

Даатгалын компанийн нийгэмд оруулж буй хамгийн том хувь нэмэр нь иргэдийг гэнэтийн эрсдэлээс үүдэн бий болох санхүүгийн хохиролд өртөхөөс хамгаалж, амьдралын хэмнэлийг нь баталгаажуулах явдал юм.

Мандал даатгал нь хувь хүн, өрх гэр, албан байгууллага тус бүр өнөөдрийг хүртэл бий болгосон өөрийн баялгийг тулгарч болох эрсдэлээс хамгаалан, маргаашийнхаа зорилгын төлөө ажиллаж, амьдардаг сайхан нийгмийг даатгалаараа дамжуулан бүтээхийг зорьдог.

ҮНЭТ ЗҮЙЛС



Нэг баг, нэг Мандал

Үргэлж түүчээл



Харилцагч нэн түрүүнд

Үйл хэрэгтээ тууштай бай



Мандалын үнэт зүйлс

Нэг баг, нэг Мандал

Бид "хувийн тоглолт"-оос илүүтэй багийн ажиллагааг дэмждэг. НЭГ БАГ, НЭГ МАНДАЛ байх нь хамтын итгэлцэл, хүндлэл, хариуцлага, хүчин чармайлтаас эхэлнэ.

Үргэлж түүчээл

Бид бусдаас үргэлж нэг алхмын урд байна. Бид бэрхшээлийг сорилт болгон харж, даван гарах хүсэл эрмэлзлээр дүүрэн байж, бүтээлч, шинийг санаачлагч сэтгэлгээгээр асуудалд хандана.

Харилцагч нэн түрүүнд

Бидний боловсруулсан шийдэл, гаргасан шийдвэр бүр харилцагчийг нэн түрүүнд тавьсан байна.

Үйл хэрэгтээ тууштай бай

Бид зорилгодоо тууштай, үйл хэрэгтээ итгэл үнэмшилтэй байж, өдөр бүр хийж буй ажлаа утга учиртай байлгана.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөг	2016	2017	2018
Нийт актив	17,309	21,472	33,784
Нөөц сан	2,224	2,911	3,383
Нийт хураамжийн орлого	13,093	22,533	27,786
Цэвэр хураамжийн орлого	4,701	10,081	16,449
Орлогод тооцсон хураамж	4,217	7,043	11,932
Нийт нөхөн төлбөр	4,116	4,706	4,324
Цэвэр нөхөн төлбөр	1,891	2,074	3,286
Үйл ажиллагааны зардал	4,281	5,549	6,320
Хөрөнгө оруулалтын орлого	994	1,227	2,248
Цэвэр ашиг/алдагдал	85	1,103	3,868

НИЙТ АКТИВ

2018 онд нийт актив өмнөх оноос 12 тэрбумаар нэмэгдсэн нь IPO гарган, 7.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн өсөлтөөс бий болсон бөгөөд активын дүнгээр салбартаа 2-р байранд, мөнгөн хөрөнгийн хэмжээгээр 1-р байранд бичигдэж байна.

ХУРААМЖИЙН ОРЛОГО

2018 он даатгалын салбарын хувьд өсөлт үзүүлсэн жил байлаа. Мандал даатгалын нийт хураамжийн орлого 27.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 23 хувиар өсчээ. Нийт хураамжийн орлого өсөхөд байгууллагын даатгалын борлуулалт, банкны даатгалын зуучлалын өсөлт болон эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний хөгжүүлэлт голлон нөлөөлсөн байна. Мандал даатгал нийт хураамжийн орлогоор салбартаа 3-р байранд орсон бөгөөд гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын хэлбэрээр салбартаа тэргүүлээ. Мөн нэг ажилтанд ногдох хураамжийн орлогоор салбартаа тэргүүлэх боллоо.

2017 оны 7-р сард давхар даатгалын нөхцөлөө өөрчилж, "Excess of loss" давхар даатгалын хэлбэрт шилжлээ. Үүний нөлөө 2018 онд үргэлжилж, Мандал даатгалын цэвэр хураамжийн орлого өмнөх оноос 63 хувиар нэмэгдэн, 16.4 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн орлогод тооцсон хураамж 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, өсөлт сайтай байгаа нь санхүүгийн голлох харьцаанууд сайжрахад нөлөөлж байна.

НӨХӨН ТӨЛБӨР

2018 онд Мандал даатгал 4.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчдад олгож, эрсдэлийг нь хамтдаа даван тууллаа. Нийт олгосон нөхөн төлбөрийн 57 хувийг тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 32 хувийг гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын нөхөн төлбөр эзэлж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

2017 онд үйл ажиллагааны зардалд 6.3 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 0.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Үйл ажиллагааны зардлын ихэнх хувийг борлуулалтын өсөлттэй холбоотой урамшуулалт цалингийн зардал, ажилчдыг мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сургалтын зардал эзэлж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО

Хөрөнгө оруулалтын орлогын суурь нь мөнгөн хөрөнгө бөгөөд 2018 онд Мандал даатгалын мөнгөн хөрөнгө 11.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 83 хувиар өсч 2.2 тэрбум төгрөгт хүрлээ.

ЦЭВЭР АШИГ

2017 оноос ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч, түүнд чиглэсэн дотоод төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн бол 2018 онд бүтээгдэхүүний чанарт түлхүү анхаарч ажилласны үр дүнд 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Харилцагчдаас хураамжийн орлого татан төвлөрүүлж, даатгалын сан үүсгэх, нөхөн төлбөр олгох, эрсдэлийг үнэлэх, зөвлөх зэрэг даатгалын үндсэн үйлчилгээг цогцоор нь **андеррайтингийн үйл ажиллагаа** гэж нэрлэдэг.

Мандал даатгалын компанийн үндсэн бизнес болох андеррайтингийн үйл ажиллагааг даатгалын багц буюу хүлээн авсан эрсдэлийн санг эрүүл, зөв бүтэцтэй байлгах, мөн гэрээгээр хүлээсэн нийт хариуцлагын хэмжээнд тохирсон нөөц сангийн бодлогыг тодорхойлох гэсэн үндсэн чиглэлүүдээр удирдан ажиллаж байна.

Мандал даатгал нь эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2018 онд тодорхой алхмуудыг амжилттай хийсний үр дүнд андеррайтингийн үзүүлэлтүүд эрс сайжирлаа. Тухайлбал, төлбөрийн чадварын зохистой харьцаа 150.6 хувьтай гарсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 40.8 нэгж хувиар нэмэгдэж, хохирлын харьцаа буюу цэвэр нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжид харьцуулсан харьцаа 28 хувьтай гарлаа. Даатгалын компанийн үйл ажиллагааны чанарыг илэрхийлдэг эдгээр үзүүлэлт сайжирч байгаа нь компанийн бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээ зохистой түвшинд байгааг харуулж байна.

БАГЦЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Андеррайтингийн эрсдэл гэдэгт даатгалын тохиолдлын давтамж болон хохирлын хэмжээнд гэнэтийн савлагаа гарч, цуглуулсан хураамжийн орлого нь ирээдүйн нөхөн төлбөр болон холбогдох зардлыг нөхөж чадахгүй болох эрсдэлийг ойлгоно.

Мандал даатгал нь багцын эрсдэлийн бодлогыг андеррайтинг, актуар болон давхар даатгалын функцүүдийг нэгтгэсэн “Даатгалын бодлогын газар”-аар дамжуулан удирддаг. Компани 2014 оноос 2017 оны эхний хагас хүртэл давхар даатгалын хэлбэр болох “Variable Quota Share Treaty” багцын эрсдэлийг хамгаалж байсан бол 2017 оны 3-р улирлаас эхлэн “Excess of Loss Treaty” давхар даатгалын хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснийг 2018 онд сайжруулан ажиллаж байна.

Мөн харилцагчийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд гаднын мэргэжлийн байгууллага, хувь хүмүүстэй хамтран харилцагч нарт зориулсан сургалт зохион байгуулах, газар дээрх эрсдэлийн үнэлгээг хийж, зааварчлан зөвлөмжлөх ажлыг зохион байгуулж байна.

Компанийн 2018 оны андеррайтингийн гол үзүүлэлтүүдийг багцын бүтэц, орлогын төвлөрөл, борлуулалтын суваг, давхар даатгал, хохирлын харьцаа болон нөхөн төлбөр гэсэн хэсгээр нэгтгэн, дараах байдлаар дүгнэв.

МАНДАЛЫН
БИЗНЕС



БАГЦЫН БҮТЭЦ

Мандал даатгал 2018 онд нийт 27.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллалаа.

Тайлбар: “Бусад” бүтээгдэхүүний хэлбэрт “Зээлийн даатгал”, “Итгэлцлийн даатгал”, “Мал амьтдын даатгал”, “Санхүүгийн даатгал”, “Ачаа тээврийн даатгал”, “Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал” зэрэг бүтээгдэхүүнийг хамруулсан болно.

Хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр	2017		2018	
	сая төгрөг	%	сая төгрөг	%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	4,944	22%	8,594	31%
Барилга угсралтын даатгал	6,282	28%	5,842	21%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,673	16%	4,670	17%
Хөрөнгийн даатгал	3,533	16%	4,125	15%
Хариуцлагын даатгал	2,302	10%	2,231	8%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,356	6%	545	2%
Бусад	444	2%	1,780	6%
Нийт	22,533	100%	27,786	100%

Хүснэгтээс харахад, “Гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал”-ын багцад эзлэх хувь өссөн байна. Үүний шалтгаан нь томоохон харилцагчдын тоо нэмэгдсэн, мөн тухайн даатгалыг бичих борлуулалтын бодлогыг өөрчилсөнтэй холбоотой юм.

Мандал даатгал нь 2018 онд 71,084 харилцагчтай даатгалын хэлцэл байгуулснаас 98 хувь нь иргэдийн даатгал, 2 хувь нь байгууллагын даатгалын харилцагчид байлаа.

2018 онд хураамжийн орлогын 42 хувь нь иргэдийн даатгалд, 58 хувь нь байгууллагын даатгалын харилцагчдад ногдож байна.

2018 оны харилцагчийн тоог 2017 онтой харьцуулан харуулбал:

Даатгалын хэлцэл	2017	2018	Өөрчлөлт
Байгууллага	1,259	1,389	10%
Иргэн	41,225	69,695	69%
Нийт	42,484	71,084	67%

Гэрээ байгуулсан нийт харилцагчийн тооны өсөлтөд сувгаар борлуулсан бүтээгдэхүүний өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Мөн нийт хураамжийн орлогыг харилцагчийн төрлөөр ангилан харвал:

Даатгалын хураамжын харьцаа	2017	2018
Байгууллага	50%	58%
Иргэн	50%	42%
Нийт	100%	100%

БОРЛУУЛАЛТЫН СУВГУУД

Мандал даатгал нь 2018 онд 27.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлснээс 36 хувийг буюу 10 тэрбум төгрөгийг даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулан олжээ.

Даатгалын зуучлагч, төлөөлөгч болон компанийн шууд бичсэн хураамжийн орлогыг 2017 оныхтой харьцуулсан байдлыг дараах хүснэгтээр харууллаа.

Даатгалын хураамж, сая төгрөгөөр	2017	2018
Шууд борлуулагч	14,839	17,804
Зуучлагч	7,043	9,640
Төлөөлөгч	651	342
Нийт	22,533	27,786

ДАВХАР ДААТГАЛ

Мандал даатгал нь 2018 онд хураамжийн орлогын 35 хувийг давхар даатгалд шилжүүлсэн нь 2017 оныхтой харьцуулахад 16 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Үүний шалтгаан нь компани “Excess of Loss Treaty” хэлбэрийг үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн хэрэгжүүлж, өөрийн хариуцах хэсэг болох 50 мянган ам.долларыг 2018 оны 4-р улиралд 120 мянган ам.доллар болгон нэмэгдүүлсэн юм. Өөрийн хариуцах хэсгийг нэмэгдүүлэх болсон нь компани, хөрөнгийн зах зээлийн нээлттэй хувьцаат компани болж, хөрөнгө босгон, эрсдэл даах чадвараа нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Даатгалын хэлбэр бүрийн хураамжийн орлогын давхар даатгалд шилжүүлсэн хувийг 2017 оныхтой харьцуулсан үзүүлэлтийг харвал дараах байдалтай байна. Үүнд:

Давхар даатгалд шилжүүлсэн хувь, даатгалын хэлбэрээр	2017	2018
Барилга угсралтын даатгал	100%	100%
Хөрөнгийн даатгал	62%	47%
Хариуцлагын даатгал	51%	33%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	21%	6%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	21%	1%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	35%	0%
Бусад	44%	75%
	54%	35%

2018 оны 4-р улиралд сунгасан “Excess of Loss Treaty” хэлбэрийн хамгаалалтын хэмжээг 3 сая ам.доллараас 5 сая ам.доллар болгон өсгөлөө.

Давхар даатгалын тус хэлбэрт “Хөрөнгийн даатгал”, “Хариуцлагын даатгал”, “Барилга угсралтын даатгал”, “Ачаа тээврийн даатгал” болон “Тусгай зориулалтын хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал”-ыг хамруулсан бөгөөд хамгаалалтын хязгаараас давсан гэрээ болгоныг тухай бүрт нь факультатив давхар даатгалд хамруулж байна. Харин энэхүү хөтөлбөрт хамрагдаагүй бусад хэлбэрийн даатгалын авсан эрсдэлүүд нь жижиг, тархсан байдаг тул компани өөрөө даах бололцоотой учраас багцын даатгалд хамруулах шаардлагагүй гэж үзэж байна.

Тухайлбал, “Excess of Loss Treaty”-д хамрагдаагүй “Авто тээврийн хэрэгслийн даатгал”, “Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал”, “Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-ын зүйлийн үнэлгээг интервалд хуваан харвал дараах байдалтай байна.

Даатгалын хэлбэр	0 - 120 мян \$	120 мян \$ дээш
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	100%	0%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	100%	0%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	99%	1%
Сайн дурын жолоочийн хариуцлагын даатгал	98%	2%

Хүснэгтээс харвал, багцын даатгалд хамрагдаагүй бүтээгдэхүүний хэлбэрийн хувьд 297.6 сая төгрөгөөс дээш үнэлгээтэй зүйлийн тоо 1 хувьд ч хүрэхгүй байгаа бөгөөд энэ нь эрсдэл хангалттай түвшинд таран байршсан байгааг илтгэнэ.

ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Компанийн 2018 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос буурч, 28 хувь болсон үзүүлэлттэй байна.

Хамгийн өндөр хураамжийн орлоготой даатгалын 6 хэлбэрийн хохирлын харьцааг өмнөх оныхтой харьцуулахад дараах байдалтай байна.

Хохирлын харьцаа, даатгалын хэлбэрээр	2017	2018
Барилга угсралтын даатгал	10%	0%
Хөрөнгийн даатгал	10%	4%
Хариуцлагын даатгал	2%	3%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	10%	24%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	53%	47%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	72%	74%
Бусад	44%	25%
	31%	28%

НӨХӨН ТӨЛБӨР

Мандал даатгал нь 2018 онд 7,294 даатгалын тохиолдолд нийт 4.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд даатгалын тохиолдлын тоог даатгалын хэлбэрээр өмнөх оныхтой харьцуулан харвал дараах байдалтай байна.

Нөхөн төлбөрийн тоо, даатгалын хэлбэрээр	2017		2018	
	Тохиолдлын тоо	Хувь	Тохиолдлын тоо	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,058	14%	3,531	48%
Автотээврийн хэрэгслийн даатгал	3,297	43%	2,609	36%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	3,078	40%	931	13%
Хөрөнгийн даатгал	139	2%	195	3%
Хариуцлагын даатгал	31	0%	16	0%
Бусад	42	1%	12	0%
Нийт	7,645	100%	7,294	100%

Олгосон нөхөн төлбөрийн дүнгийн хувьд 2017 оныхтой харьцуулахад 8 хувиар буурсан бөгөөд энэ нь зарим даатгалын хэлбэр дэх нөхөн төлбөрийн хэмжээ буурснаас шалтгаалсан байна. Тухайлбал, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-д олгосон нөхөн төлбөрийн хэмжээ голлон нөлөөлсөн байх жишээтэй.

Харин олгосон нөхөн төлбөрийг өнгөрсөн онтой харьцуулан, бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харуулбал:

Нийт нөхөн төлбөр, даатгалын хэлбэрээр	2017		2018	
	Сая төгрөгөөр	Хувь	Сая төгрөгөөр	Хувь
Автотээврийн хэрэгслийн даатгал	1,763	37%	1,961	45%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	649	14%	1,388	32%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	1,447	31%	505	12%
Хөрөнгийн даатгал	253	5%	175	4%
Хариуцлагын даатгал	235	5%	161	4%
Бусад	358	1%	134	3%
Нийт	4,706	100%	4,324	100%

Өнгөрсөн онд төлсөн 4.3 тэрбум нөхөн төлбөрийн 18 хувийг давхар даатгагчаар төлүүлсэн бол үлдсэн 3.5 тэрбум төгрөг буюу 82 хувийг Мандал даатгал хариуцан төлсөн байна.

Компанийн төлсөн цэвэр нөхөн төлбөрийг хүснэгтээр харуулбал:

Цэвэр нөхөн төлбөр, даатгалын хэлбэрээр	2017		2018	
	Сая төгрөгөөр	Хувь	Сая төгрөгөөр	Хувь
Авто тээврийн хэрэгслийн даатгал	904	42%	1,815	51%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	313	14%	1,058	30%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	819	38%	420	12%
Хөрөнгийн даатгал	94	4%	112	3%
Хариуцлагын даатгал	17	1%	32	1%
Бусад	25	1%	98	3%
Нийт	2,172	100%	3,534	100%

ТАТГАЛЗСАН НӨХӨН ТӨЛБӨР

Мандал даатгал нь гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу даатгуулагчдын хохирлыг барагдуулж, нөхөн төлбөр олгон ажилладаг ч зарим үед нөхөн төлбөр олгохоос татгалзах тохиолдлууд гардаг. Тухайлбал, 2018 онд Иргэдийн даатгалын газрын хувьд 674 даатгалын тохиолдолд татгалзсан шийдвэр гаргасан нь нийт шийдэгдсэн нөхөн төлбөрийн 8 хувийг эзэлж байна. Эдгээр татгалзсан тохиолдлуудын багагүй хэсэг нь даатгуулагч мэдэгдэх шаардлагатай хугацаандаа хохирлыг мэдэгдээгүй учраас уг хохирлыг нотлох боломжгүй болгосон, эсвэл даатгалын гэрээнд заагаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол гэх зэрэг юм.

Мандал даатгал нь итгэл хүлээлгэсэн олон мянган даатгуулагчийн даатгалын хураамжийг төвлөрүүлэн, даатгалын нөөц сан буюу дундын санг үүсгэж, түүнийг зүй зохистой зарцуулах замаар эрсдэл тохиолдсон даатгуулагчийн санхүүгийн хүндрэлийг бууруулдаг бөгөөд энэхүү санг хамгаалах үүргийг хүлээдэг. Нийт даатгуулагчийн хөрөнгөөр бүрдүүлсэн дундын нөөц сангаас даатгалын гэрээний нөхцөлийг зөрчсөн болон даатгалын гэрээгээр хамгаалагдаагүй хохиролд нөхөн төлбөр олгох нь сангийн нөөцийн хэмжээг бууруулах, хураамжийн хэмжээг хөөрөгдөх сөрөг талууд бий болгож, шударга даатгуулагчдыг хохироох эрсдэлтэй тул компани нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн үйл явцад туйлын хянамгай хандан ажилладаг.

НӨӨЦ САНГИЙН ТООЦООЛОЛ

Мандал даатгал нь даатгалын тухай хуулийн дагуу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор нөөц сан байгуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 3-р сарын 11-ий өдрийн “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын хүрээнд нөөцийн тооцооллыг хийж байна.

2018 оны эцэст 3.3 тэрбум төгрөгийн нөөц байгуулснаас давхар даатгалд ногдох хэсэг нь 548 сая төгрөг байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бонд болон хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт 4 тэрбум төгрөгт хүрч, Монголын хөрөнгийн зах зээлийн институциональ хөрөнгө оруулагч боллоо.

Аливаа даатгалын компани нь өөрийн ашиг сонирхлоо даатгуулж буй маш олон тооны даатгуулагчаас цугларсан даатгалын хураамжийг даатгалын сан (нөөц сан) хэлбэрээр байршуулж, тэдгээр даатгуулагчдад гэрээнд заасан, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийн бодит хохирлыг төлөх, даатгуулагчдын санхүүгийн найдвартай ар тал байх үүрэгтэй. Даатгалын компани нь нөөц санг заавал мөнгөн хэлбэрээр, дүрмийн сан (эздийн өмч)-г аль болох мөнгөн хэлбэрээр, эсвэл мөнгө болон хөрвөх чадвар сайтай бусад хөрөнгө хэлбэрээр байршуулдаг.

Мандал даатгалын хувьд 2018 оны 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн хөрөнгийн бүтцийг хүснэгтээр (дэлгэрэнгүйг аудитлагдсан тайлангаас харна уу) авч үзвэл:

Үзүүлэлт, сая төгрөгөөр	Дүн	Эзлэх хувь
Авллага	4,817	14%
Бусад санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө	1,537	5%
Даатгалын хөрөнгө	3,889	12%
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө	385	1%
Мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт	22,919	68%
Үл хөдлөх хөрөнгөөрх хөрөнгө оруулалт	237	1%
Нийт	33.784	100%

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын тухай дэлгэрэнгүй авч үзье.

Мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт нь компанийн нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг буюу 68 хувийг бүрдүүлж байна. Нэг талаас харахад, мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт нь нөөц сан болон дүрмийн санг бүрдүүлэх чухал үзүүлэлт бөгөөд нөгөө талаар даатгалын компанийн ашгийг бий болгогч томоохон хүчин зүйл болох юм. Өөрөөр хэлбэл, даатгалын компани нь андеррайтингийн үйл ажиллагаанаас гадна хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн зохицуулалттай байдаг.

Компанийн мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын үлдэгдлийг сүүлийн 3 жилээр харвал:

Үзүүлэлт, сая төгрөгөөр	2016	2017	2018
Бэлэн мөнгө	8	1	4
Банкан дахь мөнгөн хөрөнгө (хүүгийн авлагын хамт)	6,469	8,634	18,736
Засгийн газрын бонд (хүүгийн авлагын хамт)	-	1,137	260
Компанийн бонд (хүүгийн авлагын хамт)	-	553	3,262
Банк бус санхүүгийн байгууллага дахь мөнгөн хөрөнгө	500	700	200
Хувьцаа	-	-	457
Үл хөдлөх хөрөнгөөрх хөрөнгө оруулалт	237	237	237
Нийт	6,977	11,035	22,919

Компани нь Удирдлагын хорооны дэргэдэх Хөрөнгө оруулалтын дэд хороотой бөгөөд тус дэд хорооны үндсэн чиг үүрэг нь судалгаанд суурилсан эрсдэл багатай, өгөөж сайтай хөрөнгө оруулалт хийх юм.

Компанийн мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын эрсдэл, өгөөжийн байдлыг товч авч үзвэл:

1. Банкан дахь мөнгөн хөрөнгийн байршлын эрсдэл:

Олон улсын үнэлгээний байгууллагын үнэлгээ	2016	2017	2018
Рейтингтэй арилжааны банкинд байршуулсан	55%	80%	72%
Рейтинг тогтоолгоогүй арилжааны банкинд байршуулсан	45%	20%	28%
Нийт	100%	100%	100%

2. Засгийн газрын бонд нь ямагт эрсдэлгүй хөрөнгө оруулалтад тооцогддог бөгөөд компанийн худалдан авсан бонд нь өгөөж сайтай үед худалдан авсан бонд болно.
3. Сүүлийн жилүүдэд компаниуд өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор бонд гаргах нь түгээмэл болсон байна. Мандал даатгалын хувьд үйл ажиллагаа нь өргөжиж, амжилттай ажиллаж буй компаниудын бондыг "Хөрөнгө оруулалтын дэд хороо"-ны судалгааны дагуу худалдан авснаар, уламжлалт хөрөнгө оруулалтаас илүү их өгөөжийг хүртэж байна.
4. Банк бус санхүүгийн байгууллага дахь мөнгөн хөрөнгө нь нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагад байршиж байгаа бөгөөд уламжлалт хөрөнгө оруулалтаас илүү их өгөөжийг санал болгодог.
5. Компани нь урт хугацаанд арвин үр өгөөж хүртэх зорилгоор тодорхой хязгаарт компанийн хувьцааг худалдан авч байна.
6. Компани нь түрээсийн орлого олох, капиталын үнийг өсгөх зорилготойгоор үл хөдлөх хөрөнгөөрх хөрөнгө оруулалт хийх боломжтой. Компани нь капиталын үнийг өсгөх зорилготойгоор худалдан авсан үл хөдлөх хөрөнгөө 2019 онд борлуулна.

2018 онд Мандал даатгал нь мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын хэмжээгээр салбартаа тэргүүлж байна. Үүний нэг жишээ нь, бонд болон хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт 4 тэрбум төгрөгт хүрч, Монголын хөрөнгийн зах зээлийн институциональ хөрөнгө оруулагч боллоо.

Хөрөнгийн зах зээл дээрх санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах нь тухайн зах зээлийн хөгжилд эергээр нөлөөлөх юм.

Сүүлийн жилүүдэд мөнгөний бодлогын хүү буурч байгаа ч компанийн борлуулалтын өсөлт, давхар даатгалын бодлогын оновчлол, авлага барагдуулалтын сайжрал, 2018 онд IPO гаргасан зэрэг нь мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын хэмжээнд томоохон нөлөөллийг бий болгосон байна.

Хөрөнгө оруулалтын орлогыг сүүлийн 3 жилээр харвал:

Үзүүлэлт, сая төгрөгөөр	2016	2017	2018
Банкан дахь харилцах дансны хүүгийн орлого	28	28	28
Банкан дахь хадгаламж, хадгаламжийн сертификатын дансны хүүгийн орлого	724	766	1,623
Засгийн газрын бондын хүүгийн орлого	37	234	79
Компанийн бондын хүүгийн орлого	-	39	329
Банк бус санхүүгийн байгууллагын хүүгийн орлого	106	129	89
Бусад хөрөнгө оруулалтын орлого	127	60	128
Нийт	994	1,227	2,248

Мандал даатгал нь Даатгалын тухай хуулийн 27.1.5-д "Даатгалын компанийн дүрмийн сангийн болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох этгээд болон түүний үүсгэн байгуулсан банкинд байршуулахыг хориглоно" гэж заасны дагуу аливаа холбогдох этгээдэд мөнгөн хөрөнгө байршуулаагүй.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНДСЭН ФУНКЦУУД

БИЗНЕС ХӨГЖИЛ БОРЛУУЛАЛТ

Харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, амьдралд ойрхон, шинэлэг даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, хамгийн үр ашигтай сувгаар хүргэх нь бизнес хөгжил болон борлуулалтын функцүүдийн гол үүрэг юм.

Бизнес хөгжил болон борлуулалтын нэгжүүд нь харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, борлуулалтын үр ашгийг өсгөх зорилгоор нягт уялдаа холбоотой ажилладаг. Үүний үр дүнд Мандал даатгал нь 2018 онд компанийн нийт хураамжийн орлогоо 23 хувиар өсгөсөн амжилттай байлаа. Дээрх өсөлтийг үзүүлэхэд эрүүл мэндийн даатгалын хураамжийн орлого 74 хувиар, авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн орлого 27 хувиар, хөрөнгийн даатгалын хураамжийн орлого 17 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

Хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр, сая төгрөгөөр	2016	2017	2018	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,848	4,944	8,594	74%
Барилга угсралтын даатгал	170	6,282	5,842	-7%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,531	3,673	4,670	27%
Хөрөнгийн даатгал	3,022	3,533	4,125	17%
Хариуцлагын даатгал	2,053	2,302	2,231	-3%
Бусад	3,469	1,800	2,325	29%
Нийт	13,093	22,533	27,786	23%

Мандал даатгал нь байгуулагдсан цагаас хойш салбартаа шинэлэг шийдлийг нэвтрүүлж, даатгуулагчдын хүсэл шаардлагад нийцсэн даатгалын үйлчилгээг үзүүлэхийг эрмэлзэн ажиллаж ирлээ. Үүний дагуу компанийн бизнес хөгжил, борлуулалтын функцүүдийн бодлого нь бүтээгдэхүүний чанар, зах зээлд өрсөлдөх чадвар болон, даатгуулагчдад хүргэх борлуулалтын сувгийг үр ашигтайгаар шийдэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

2018 онд “Жаргалан” эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнээ шинэ багцуудаар баяжуулж, сувгийн борлуулалтад шинэ бүтээгдэхүүн болох бизнесийн зээлийн даатгалыг хөгжүүллээ. Мөн уламжлалт борлуулалтын сувгийг цахимжуулах эхний алхмыг хийж, гар утаснаасаа даатгуулах шийдлийг амжилттай хэрэгжүүллээ.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

“Жаргалан” даатгалын шинэ багц

Мандал даатгал нь 2015 онд Монгол Улсын анхны хувийн эрүүл мэндийн даатгал “Жаргалан”-г зах зээлд нэвтрүүлсэн билээ. Түүнээс хойш харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, бүтээгдэхүүнээ тасралтгүй сайжруулсаар ирсэн бөгөөд 2018 онд “Жаргалан” эрүүл мэндийн даатгалын нэмэлт 2 багцыг шинээр хөгжүүлж, зах зээлд борлуулж эхэллээ. Үүнд:



Аз жаргалаа дархлаа
ЖАРГАЛАН

- ЖАРГАЛАН ПЛАС 30 БАГЦ**
Энэхүү багц нь Монгол Улсад 30 сая төгрөг хүртэлх эмчилгээ үйлчилгээг авах боломжтой бөгөөд нэмэлтээр урьдчилан сэргийлэх үзлэг болон хөдөлмөрийн чадвар алдалтыг хамгаалах зориулалттай цогц даатгал юм.
- ЖАРГАЛАН СОЛОНГОС БАГЦ**
Монгол Улсаас гаднын оронд тэр дундаа Солонгос улсад эмчлүүлдэг иргэдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа билээ. Бид энэхүү хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, “Жаргалан” эрүүл мэндийн даатгалын Солонгос багцыг нэвтрүүллээ. Энэхүү даатгалд хамрагдсанаар 1 жилийн хугацаанд Монгол, Солонгос улсын сүлжээ эмнэлгүүдээс 50 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий эмчилгээ үйлчилгээг авах боломжтой.

Ингэснээр “Жаргалан” сайн дурын эрүүл мэндийн даатгал нь Үндсэн багц, Ази багц, Плас 30 багц, Солонгос багц гэсэн 4 төрлийн, өөр өөрийн онцлог бүхий багцтай болж, үйлчилгээний төрлөө нэмэгдүүлэн, сайжрууллаа.

Үүний үр дүнд 2018 онд сайн дурын эрүүл мэндийн даатгалын зах зээлд №1 даатгагч болж, хувийн эрүүл мэндийн даатгалын зах зээлийн 60%-ийг дангаараа бүрдүүлсэн амжилттай байлаа.



Бизнесийн зээлийн даатгал

Сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарын эрсдэл нэмэгдэж, чанаргүй зээл 2018 онд 10.4 хувь болж өсчээ. Үүнээс хувийн хэвшилд олгосон зээл 85 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд эдгээрийн олонх нь бизнесийн байгууллага байна. Бизнесийн байгууллагууд хөрөнгө барьцаалж зээл авдаг ч тухайн барьцаа эвдэрч сүйдэн, ямар нэгэн хохирол учирснаар компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөс гадна зээлийн чанар, эргэн төлөлтийг муутгадаг эрсдэл бий. Тиймээс бизнесийн байгууллагуудын зээлийн барьцаанд буй хөрөнгөд учрах даатгалын эрсдэлийг хамгаалах замаар зээлийн эрсдэлийг бууруулах, байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааны хэмнэлийг алдагдуулахгүй байх зорилгоор бизнесийн зээлийн даатгалыг шинээр хөгжүүлж, арилжааны банкуудтай хамтран үйлчилгээндээ нэвтрүүлээ.

ГАР УТАСНААСАА ДААТГАЛ АВАХ БОЛОМЖ

Технологийн дэвшил улам хурдасч, бизнесийн бүхий л салбар энэхүү дижитал шилжилтэд дасан зохицох шаардлагатай болж байна. Тэр дундаа санхүүгийн салбарт хувьсгал гарч, fintech, insurtech гэх ойлголтууд хүч түрэн, уламжлалт бизнес модельтой өрсөлдөж эхэллээ.

Мандал даатгал нь дээрх орчны өөрчлөлтийг ашиглан, гар утаснаасаа төлбөрөө төлж шууд даатгуулах боломжийг Social pay аппликейшнээр дамжуулан, Монголд анх удаа амжилттай хэрэгжүүллээ. Дээрх ажлын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт аялж байх үеийн гэнэтийн ослоос хамгаалах “Замд гаръя” бичил даатгалыг хөгжүүлж гаргасан нь даатгуулагч нар хугацаа болон хамгаалалтын хэмжээг сонгох боломж бүхий уян хатан нөхцөлтэй бүтээгдэхүүн болжээ.

БОРЛУУЛАЛТ ДЭМЖИХ УРАМШУУЛАЛТ АЯН

Мандал даатгал нь сайн дурын даатгалын борлуулалтын хэмжээг өсгөх, харилцагчдын бааз сууриа нэмэгдүүлэх зорилгоор жил бүр урамшуулалт аян зохион байгуулж байна. 2018 онд уламжлал ёсоор “Тээврийн хэрэгслийн даатгал”-ын хавар, намрын урамшуулалт аяныг амжилттай зохион байгуулж, “Авто тээврийн хэрэгслийн даатгал”-ын хураамжийн орлогыг 27 хувиар өсгөлөө. Мөн 2018 онд анх удаагаа хувийн эрүүл мэндийн даатгалын урамшуулалт аяныг зохион байгуулж, маш амжилттай ажиллаж, сайн дурын даатгалын хураамжийн орлогоо 74 хувиар нэмэгдүүллээ.

ҮЙЛЧИЛГЭЭ НӨХӨН ТӨЛБӨР

Даатгалын тохиолдол бий болсон үед харилцагчид хүлээлтийн зөрүүгүй, сэтгэл ханамжтай үйлчилгээг үзүүлэх нь даатгалын үйлчилгээний хамгийн чухал зүйл юм.

2017 онд Мандал даатгал нь нөхөн төлбөрийн үйлчилгээг үзүүлэхдээ “хурд” гэдэг хэмжигдэхүүнийг 3 төрлөөр тодорхойлж, харилцагчдадаа хэрхэн шуурхай үйлчлэх талаар шат дараалсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн билээ. Тэгвэл 2018 онд дотоод процессыг хэвшүүлж, хурдан холбогдож, хурдан баримтжуулж, хурдан шийдвэрлэхээс гадна “хүртээмжтэй үйлчилгээ”, “тухтай үйлчилгээ”-г үзүүлэхээр зорин ажиллаж байна.

ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ


Өнөөгийн нийгмийн хүндрэлтэй асуудлуудын нэг болох замын түгжрэлийн улмаас харилцагчид ослын газарт тодорхой хугацаагаар хүлээх, ослын улмаас олон тийш явах шаардлага байсаар байна. Мандал даатгал нь үүнийг шийдвэрлэх хэд хэдэн ажил хийж гүйцэтгэлээ.

Хурдан баримтжуулах

2017 онд Мандал даатгал нь гурван дугуйтай скүүтерийг үйлчилгээндээ нэвтрүүлж, замын түгжрэлд өртөхгүйгээр даатгалын тохиолдол болсон цэгт түргэн шуурхай очиж эхэлсэн бол, 2018 онд шуурхай дуудлагын ажилтнуудынхаа тоог 30 хувиар нэмэгдүүллээ. Түүнчлэн Улаанбаатар хотыг бүсчлэн хувааж зөв цэгт байршсанаар осол болсон газарт хамгийн илүү хурдан очих боломжтой болсон байна.

Үйлчилгээний цэг

Мандал даатгал нь 2018 онд харилцагчдадаа улам ойртож, үйлчилгээний цэгийг хоёроор нэмэгдүүлсэн билээ. “Зайсан Хилл” комплекст байршсан цэгээр харилцагчид даатгалын бүх төрлийн үйлчилгээг авах боломжтой боллоо. Мөн эрүүл мэндийн даатгалын хамгийн их үйлчилгээ үзүүлдэг Интермед эмнэлэг дээр эрүүл мэндийн нөхөн төлбөрийн болон бусад мэдээлэл, лавлагааны үйлчилгээг үзүүлэх цэг ажиллуулж байна.



Цахим үйлчилгээ

Өнөө цагийн байгууллагуудын үйл ажиллагаа улам бүр автоматжиж, цахим хэлбэр лүү шилжиж байна. Мандал даатгал нь үүнтэй мөр зэрэгцэн, энэхүү шилжилтийг хийх төслийг амжилттай эхлүүлээд байна. Даатгалын үйлчилгээг мобайл аппликэйшнээр дамжуулан харилцагчид хүртээмжтэйгээр хүргэх төслийн эхний үе шатыг дуусгалаа. Тус мобайл аппликэйшнээр дамжуулан харилцагч гэрээний мэдээлэл, нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн мэдээлэл, даатгалын түүх зэргийг харж, ослын баримтжуулалт хийх боломжтой. Төслийн дараагийн үе шат нь харилцагч даатгалын үйлчилгээний төвд ирэхгүйгээр даатгалын бүхий л үйлчилгээг авах шийдлүүдийг нэмж, сайжруулалт хийхээр ажиллаж эхлээд байна.

Байгууллагын харилцагчдын тасралтгүй харилцаа

Мандал даатгал нь харилцагч байгууллагуудын эрсдэлийг шилжүүлэн авч, хариуцлага хүлээдэг учраас тэдэнтэй нягт уялдаа холбоотой ажилладаг. Харилцагч байгууллагуудын эрсдэлийг таньж мэдэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж, түүнийг бууруулах зөвлөмж мэдээллээр хангах, сургалт семинарыг цаг алдалгүй зохион байгуулах, нөхөн төлбөрийн тухай тайлан мэдээллээр тогтмол хангах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж, тасралтгүй харилцаа холбоотой байхыг эрмэлзэн ажиллаж байна. Харин даатгалын тохиолдол болсон үед ослын газарт хурдан шуурхай ажиллаж, зааварлан зөвлөмжлөхөөс гадна нөхөн төлбөрийн шаардлагатай материалыг хамтран бүрдүүлж, асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэхээр зорин ажиллаж байна.



ТУХТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Тухлаг орчин

Харилцагчдад сэтгэл ханамжтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор илүү тав тухтай, орчин үеийн интерьер дизайныг шингээсэн, тайван орчныг бүрдүүлсэн шинэ үйлчилгээний төвийн байранд нүүж орлоо.

Найрсаг харилцаа


Мандал даатгал компани үйлчилгээний ажилчдын харилцаа, харилцагчид үйлчлэх үйлчилгээний стандартыг дараагийн түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран, урт хугацааны төслийг эхлүүлээд байна. 2019 оны турш үргэлжлэх уг төслөөр салбарынхаа даатгалын үйлчилгээний жишгийг тогтоох томоохон зорилгыг тодорхойлон ажиллаж байна.

2018 ОНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО БАРИМТУУД

Үйлчилгээний төв



Лавлах төв



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Мандал даатгал нь технологийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан дата төв, программ хангамж дэд бүтцийг стандартын дагуу байгуулан, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Бүтээмжийг дээшлүүлэх, даатгалын мэдээллийн санг бүрдүүлэх, цахим эрсдэлээс сэргийлэх хүрээнд дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

Бүтээмжийг дээшлүүлэх

Систем болон программ хангамжийн хөгжүүлэлтийг тасралтгүй хийж, 2018 оны байдлаар компьютер тоног төхөөрөмж, программууд дээр 755 хүсэлтийг хүлээн авч, 1000 орчим хөгжүүлэлт хийгдсэний үр дүнд бүтээмжийг дээшлүүлж, нийт 8,000 орчим хүн цаг хэмнэсэн байна.

Мэдээллийн санг бүрдүүлэх

Зах зээлд нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд хэрэглэгддэг даатгалын үндсэн системийн тусламжтай харилцагчийн даатгалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллүүдийг үнэн зөвөөр авах боломжтой.

Мандал даатгал нь үүсгэн байгуулагдсанаас хойших түүхэн өгөгдлүүдийг үүсгэн, ажилтнуудынхаа хэрэгцээ шаардлагын дагуу цаг тухайд бүрд нь боловсруулан, тайлан мэдээг бэлтгэж байна.

Эрсдэлээс сэргийлэх

Даатгалын үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчид болон ажилтнуудыг санаатай, санамсаргүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын гэрээг системээс хэвлэх ослын үеийн нөхцөл байдлыг онлайнд баримтжуулах зэрэг эрсдэлээс сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ПРОГРАМ ХАНГАМЖ

Компанийн үйл ажиллагааны түргэн шуурхай, найдвартай чанартай байдлыг бүрэн хангах үүднээс даатгалын үндсэн бүртгэл, шуурхай дуудлага, харилцагчийн үйлчилгээ, дотоод хүний нөөцийн Интранет зэрэг системийг хөгжүүлж чадлаа.

- Даатгалын үндсэн систем: Даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх, тооцоолох, тайлагнах зорилго бүхий цогц систем
- Шуурхай дуудлагын систем: Нөхөн төлбөрийн тохиолдлыг бүртгэх, тайлагнах, зохицуулах үүрэг бүхий систем
- Харилцагчийн үйлчилгээний систем: Харилцагчийн дуудлага авах, бүртгэх, тайлагнах үүрэг бүхий (call center) систем
- Интранет Систем: Компанийн дотоод хэрэгцээнд зориулагдсан систем

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭД БҮТЭЦ

Орчин үеийн шинэлэг технологийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг цаг тухай бүрт нь түргэн шуурхай шийдэж, мэдээллийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг бүрэн ханган ажиллаж байна.

- ДАТА төв: Зориулалтын тусгай орчинд стандартын дагуу тоноглогдсон дата төвд мэдээллийн технологийн чиглэлээр явуулж буй бүх үйлчилгээг төвлөрүүлэн, өгөгдлийн найдвартай байдлыг хангахын тулд их хэмжээний мэдээлэл хадгалах төхөөрөмжийн шийдлийг нэвтрүүлж, Microsoft дата төв дээр давхар хадгалах шийдлийг нэвтрүүлэн ажиллалаа.
- Ажиллах орчин: Байгууллагын хэмжээнд ажилтны өдөр тутам ашиглаж байгаа программ хангамжуудыг лицензжүүлж, Microsoft office 365 шийдлийг албан ёсоор нэвтрүүлээ. Мөн тоног төхөөрөмж, дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах үүднээс тоног төхөөрөмж, дэд бүтэц, нийт ажилтны ашиглаж байгаа тоног төхөөрөмжүүдэд шинэчлэл хийж, дотоод сүлжээг стандартын дагуу дахин суурилууллаа.
- Үйлчилгээний заал: Үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс үйлчлүүлэгчийн дараалал тогтоох системийн шинэчилсэн, хяналтын камерын технологийг бүрэн нэвтрүүлэв.
- Системийн аюулгүй ажиллагааг дэмжих хамгаалалт: Вэб дээр суурилсан программ хангамжуудаа SSL сертификатжуулав. И-мэйлийн серверийн үйлчилгээ хангах явцад гарч болох гаднын халдлагаас Microsoft online protection үйлчилгээг ашиглан сэргийлж байна. Компанийнхаа дата төвд учирч болох гаднын халдлагаас сэргийлэх зорилгоор зориулалтын Hardware Firewall төхөөрөмжөөр хамгааллаа.

ХҮНИЙ НӨӨЦ


Эерэг хандлага, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэл бүхий бүтээмжтэй ажилтан нь манай компанийн өрсөлдөх чадварын үнэ цэнтэй хүчин зүйл юм.

Мандал даатгал нь даатгалын салбарт мэргэшсэн туршлагатай 105 үндсэн ажилтантай бөгөөд эерэг хандлага, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэл бүхий бүтээмжтэй ажилтан нь манай компанийн өрсөлдөх чадварын үнэ цэнтэй хүчин зүйлийн нэг юм.


2018 онд бид, ажилтнуудаа сургаж хөгжүүлэх, багийн ажиллагааг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг урамшуулах, идэвхжүүлэхэд түлхүү анхаарч ажилласан жил байлаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОО БАРИМТУУД

Ажилтны хүйсийн харьцаа



Компанид ажилласан жил



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БОДЛОГО

Мандал даатгал нь хүний нөөцийн бодлого, тэр дундаа сонгон шалгаруулалтын бодлогын хүрээнд ХҮН БҮРТ-ТЭГШ БОЛОМЖ олгох суурь зарчим баримталдаг бөгөөд уг бодлогынхоо хүрээнд “5/500” хөтөлбөрийг 2015 оноос хойш амжилттай хэрэгжүүлсээр ирлээ. Уг хөтөлбөрийн онцлог, давуу тал нь манай компанийг сонирхон ажил горилж буй хүн бүхэнд сонгон шалгаруулалтад

оролцох эрхийг нээлттэй, тэгш олгодог бөгөөд төгссөн сургууль, ажилласан туршлагаас үл хамааран, хөтөлбөрийн явцад тухайн ажил гориллогчийн ХАНДЛАГА, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ, ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ-д тулгуурлан, сонгон шалгаруулж, ажлын санал тавьдаг гэдгээрээ бусад компанийн сонгон шалгаруулах арга техникээс ялгардаг.

Уг хөтөлбөрийн ялгарах онцлог нь бид хүмүүсийг эхэлж сонгон шалгаруулах биш, байгууллагаа танилцуулан, цаашид орж ажиллах сонирхолтой эсэхийг ажил гориллогч нарт эхний сонголт болгодоороо ялгаатай. 2018 онд “5/500” хөтөлбөрөөр 9 ажилтныг сонгон шалгаруулж, ажилд авсан байна.

Мандал даатгал нь албан тушаалын зэрэглэл, онцлогоос хамааран, ахлах менежер болон түүнээс дээш түвшний албан тушаалуудын сонгон шалгаруулалт хийхдээ ажилтан зуучлах “Дотоод зуучлалын хөтөлбөр”-ийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд хувь хүний хандлагад суурилсан буюу компанийн соёл, үнэт зүйлд нийцэхүйц эерэг, зөв хандлагатай, тодорхой шалгуур хангасан хүмүүсийг компанидаа амжилттай зуучлан, хөдөлмөрийн гэрээ байгуулж, жинхэлж чадсан ажилтандаа мөнгөн урамшуулал олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж, сонгон шалгаруулалтын бас нэгэн шинэлэг арга, техникийг компанидаа нэвтрүүлээд байна.

КАРЬЕР, СУРГАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Мандал даатгал нь 2018 онд ажилтнуудынхаа сургалт хөгжилд түлхүү анхааран ажилласан жил боллоо. Нийт ажилтны 70 гаруй хувийг мэргэшүүлэх сургалтад хамруулан ажиллалаа. Ажилтнуудынхаа аюулгүй ажиллагаанд анхааран, сургалт хөгжлийн төлөвлөгөөнд Хөдөлмөр хамгааллын сургалт оруулахаар төлөвлөж, сургалтзөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Мандал даатгал нь нээлттэй ажлын байрыг дотооддоо эхлэн зарлаж, ажилтнуудаас сонгон шалгаруулж авдаг нь хувь хүний хөгжил, карьер хөгжлийг дэмжсэн бодлогын хэрэгжилт билээ.

Маркетингийн менежерээр ажлын гараагаа анх эхэлсэн Маркетинг, бизнес хөгжил хариуцсан захирал, шинжээчээр ажлын гараагаа эхэлсэн Үйл ажиллагаа хариуцсан захирлууд 2018 онд удирдлагын багт шинээр орсон нь карьер хөгжлийн бодлогын хэрэгжилтийг харуулсан бодит үр дүн юм.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО

Мандал даатгалын нэвтрүүлэн хэрэгжүүлж буй “Гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоо” нь ажилтан бүрийн ажил үрэг тодорхой, ойлгомжтой болж, ажлынхаа зорилгыг ухамсарлан, хамтын хүчээр бүтээмжтэй ажиллах суурь нөхцөлийг бий болгохын зэрэгцээ бүтээмжтэй, сайн ажилласан ажилтнуудаа урамшуулах урамшууллын систем болдгоороо онцлог давуу талтай.

Мөн бид, ажилтнуудаа мэргэшүүлэх сургалтад хамруулан, улирал тутамд аттестатчиллын шалгалт авч, тэнцсэн ажилтнуудыг KPI гүйцэтгэлийн урамшуулал олгох шалгуур үзүүлэлтүүдийн нэгийг хангасанд тооцож байгаа нь ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхээс гадна илүү мэргэшсэн боловсон хүчинтэй болж, харилцагчдад үзүүлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлсэн ажил боллоо.

УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

“Гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоо”-д суурилсан урамшууллын бодлогын хүрээнд тодорхой шалгууруудыг хангасан ажилтнууд мөнгөн урамшуулал авахаас гадна хагас жилийн KPI гүйцэтгэл хангасан ажилтнууд болон жилийн KPI гүйцэтгэл хангасан ажилтнуудаа шалгаруулан урамшуулдаг.

Хагас жилийн KPI гүйцэтгэл хангасан ажилтнуудыг Монгол орны үзэсгэлэнт газруудаар аялах эрхийн бичгээр, жилийн KPI гүйцэтгэл хангасан ажилтнуудаа гадаад орноор аялах эрхийн бичгээр тус тус шагнаж урамшуулж байна.

2018 оны хагас жилийн KPI гүйцэтгэл хангасан 25 ажилтан Архангай аймгаар аялж, амарсан бол жилийн KPI гүйцэтгэл хангасан 20 ажилтан Тайланд улсын Пукет аралд хамт олноороо аяллаа.



АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Мандал даатгал нь нийгмийн хариуцлагатай бизнес эрхэлдэг компанийн хувьд нийгэмдээ үлгэр жишээ болсон олон ажлыг хийдгийн нэг нь ажилтнуудын эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулах юм. 2018 онд бид, ажилтнуудынхаа эрүүл мэндэд чиглэсэн хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж ажилласан билээ. Үүнд, ажилтнуудыг эрүүл мэндийн бүрэн үзлэг шинжилгээнд хамруулж, “Жаргалан” эрүүл мэндийн даатгалд хөнгөлөлттэй нөхцөлөөр даатган, фитнес, бассейн, спорт заалуудтай гэрээ хийж, ажилтнуудынхаа эрүүл амьдралын хэв маягаар амьдрах нөхцөл бололцоог хангахад компанийн зүгээс санаачилга гарган ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Эрсдэлийн боловсролыг олон нийтэд түгээж, ард иргэд, албан байгууллагуудад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зан төлөвийг хэвшүүлж, эрсдэлгүй нийгмийг бүтээхэд өөрийн хувь нэмрээ оруулах нь даатгалын компанийн хувьд хамгийн том нийгмийн хариуцлага мөн.

Мандал даатгал компани нь нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд жил бүр эрсдэлийн боловсрол олгох болон нийгэм дэх эрсдэлийг бууруулах чиглэлийн ажлуудыг зохион байгуулж байна.

ЭРСДЭЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЧИГЛЭЛД

Эрсдэлийн Форум

Мандал даатгал нь албан байгууллагууд болон иргэдэд эрсдэлийн боловсрол олгох, эрсдэлийн удирдлагын шилдэг туршлагаас хуваалцах, мэдээлэл солилцох зорилгоор 2011 оноос жил бүр эрсдэлийн удирдлагын форумыг зохион байгуулж ирлээ.

2018 оны эрсдэлийн форумыг Голомт банкт хамтран зохион байгуулсан бөгөөд форумд “Эдийн засгийн өсөлтөд бизнесээ бэлдэх нь” болон “2019 оны бизнест учирч болох ТОП 3 эрсдэл” гэсэн сэдвийг хөндөж, хэлэлцүүлгүүд өрнүүллээ.

Уг арга хэмжээнд Монгол Улсын бизнесийн салбарын томоохон компаниудын шийдвэр гаргах түвшний 350 гаруй албан тушаалтан хүрэлцэн ирж оролцсон нь тус форумын ач холбогдол, үр дүн, нэр хүнд, цар хүрээ жил ирэх бүр өсөн нэмэгдэж, мөн цаг үеэ олсон чухал сэдвүүдийг хөндөж чаддагийг харууллаа.



Үндэсний суурь эрсдлийн индекс

Мандал даатгал нь 2016 оноос “Эрсдэлийн индекс”-ийг тооцоолж, олон нийтэд тогтмол танилцуулдаг болсон билээ.

“Эрсдэлийн индекс”-ээр иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө болон албан байгууллагын үйл ажиллагаанд хэмжигдэхүйц, бодит хохирол учруулдаг байгалийн гамшигт үзэгдэл, нийгмийн эрсдэлүүдийг нэгтгэн, тоон утгаар хэмжиж, эрсдэлийн түвшинг тодорхойлдог бөгөөд бидний тооцсон индексийг Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэнгээс сайшаан хүлээн авч, 2017 онд индекс тооцох аргачлалыг хамтран сайжруулж, “Үндэсний суурь эрсдэлийн индекс” хэмээн нэрлэв.

2018 онд Мандал даатгалын хамт олны зүгээс уламжлал ёсоор “Үндэсний суурь эрсдэлийн индекс”-ээ шинэчлэн тооцоолж, Монгол Улсын эрсдэлийн тоймыг зургаа дахь удаагаа бэлтгэн гаргалаа.

Олон улсад эрсдэлийн түвшинд гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, үнэлэх зорилго бүхий төрөл бүрийн судалгаа байдаг ба хэд хэдэн индексийг тооцож ашигладаг. Эдгээр индекс нь улс орон бүрийн газарзүйн байршил болон нийгмийн хөгжлөөс хамааран анхаарах эрсдэлүүд нь харилцан адилгүй байдаг учраас манай улсад ашиглахад тохиромжтой бус юм. Тиймээс манай улсад голлон тохиолддог эрсдэлийг судалж, тэдгээр эрсдэлийг үнэлэх, бууруулах арга замыг хайх, улмаар эрсдэлийн түвшинг бууруулж, тодорхой түвшинд хүргэх нь бидний индекс тооцооллын гол зорилго юм.

Монгол Улсад голлон тохиолддог нийгмийн эрсдэлүүд:


- Өвчлөлийн эрсдэл
- Гэмт хэргийн эрсдэл
- Зам тээврийн хөдөлгөөний эрсдэл
- Объектын гал түймрийн эрсдэл
- Үйлдвэрлэлийн ослын эрсдэл

Байгалийн эрсдэлүүдийн хувьд:

- Газар хөдлөлтийн эрсдэл
- Зудын эрсдэл
- Малын гоц халдварт өвчний эрсдэл
- Ой хээрийн гал түймрийн эрсдэл
- Үерийн эрсдэл
- Хүний гоц халдварт болон халдварт өвчний эрсдэл
- Хүчтэй салхи шуурганы эрсдэл

“Үндэсний суурь эрсдэлийн индекс” нь 1-9 оноогоор үнэлэгдэх бөгөөд индексийн тоон утга их байх нь эрсдэлийн түвшин өндөр байгааг илэрхийлнэ. Индексийг нэг жилийн туршид тохиолдсон эрсдэлийн статистик мэдээлэлд тулгуурлан, жилд нэг удаа тооцоолдог. 2017 онд индексийн утга 4.8 гарчээ. Мөн дээрх эрсдэлүүдийн улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөнд 1 их наяд 58 тэрбум төгрөгийн санхүүгийн “шууд” хохирол учирсан байна.





Индекс тооцож, эрсдэлийг хэмжсэнээр иргэн бүр эрсдэлийн улмаас учирч болох хор хохирлыг ойлгодог, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах арга замын талаар мэдлэгтэй байж, өөрийн өдөр тутмын ахуй амьдралдаа дадал зуршил болгон хэвшүүлэхэд тус дэм болох юм.

Иргэншилд хамтдаа: “Эрүүл мэндийн эрсдэл”-ийн боловсрол олгох нэвтрүүлэг

2017 онд Монгол Улсад эрсдэлийн улмаас эд хөрөнгө, эрүүл мэндэд учирсан санхүүгийн шууд хохирлын хэмжээ 1 их наяд 58 тэрбум төгрөг бөгөөд үүнээс эрүүл мэндэд учирсан санхүүгийн хохирол 754.8 тэрбум төгрөгийн зардал буюу нийт хохирлын 71 хувийг дангаар эзэлж байна.

Мандал даатгал, “Монгол товчоон” цуврал нэвтрүүлгийг санаачлан гүйцэтгэгч “Монгол Кино Пикчерс” компанитай хамтарч, монгол хүний эрүүл мэнддээ анхаарах хандлагын асуудлыг хөндсөн “Иргэншилд хамтдаа: ЖАРГАЛАН” нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд хүргэлээ. Уг нэвтрүүлгээр иргэдийн эрүүл мэнддээ анхаарах хэвшлийг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдаж, хүн бүрт хамгийн чухал эрүүл мэнддээ тогтмол анхаарч байхын ач холбогдлыг уран сайхны аргаар ойлгуулсан бүтээл болсон билээ.



ЭРСДЭЛ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ТӨСЛҮҮД

“Аврагчдаа аваръя” ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх төсөл

Мандал даатгалын жил бүр тооцоолон гаргадаг эрсдэлийн индексэд тусгаснаар “Ой, хээрийн гал түймрийн эрсдэл” байгалийн гамшгийн эрсдэлийн бүлэгт томоохон сөрөг нөлөө үзүүлдэг эрсдэлийн нэг юм. Ой, хээрийн түймрээс үүдэн, 2017 онд 5.9 сая га талбай шатаж, 78 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Уг эрсдэлийг бууруулахад хувь нэмрээ оруулж, Мандал даатгал “Аврагчдаа аваръя” ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нийгмийн төслийг дэмжин ажиллалаа.

Энэхүү төсөл нь “Зориг сан”-аас хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн манлайлал” хөтөлбөрийн хүрээнд Австралийн тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдийн сонгон хэрэгжүүлсэн олон нийтэд чиглэсэн сайн үйлсийн төсөл юм.

Төслийн хүрээнд:

- Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд мэдээлэл өгч, мэдлэгийг дээшлүүлэх, медиа компанит аян зохион байгуулж, видео контентууд бүтээж олон нийтэд хүргэв.
- Гал түймэртэй тэмцэхэд зориулан Michel&Amazonka-ийн дизайнаар бүтсэн, Онцгой Байдлын Ерөнхий Газрын стандартад нийцсэн галд тэсвэртэй хувцсыг үйлдвэрлэж, Төв аймгийн Заамар, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумдад байгуулагдсан сайн дурын гал сөнөөгчдийн хэсэгт хандивлалаа.



“Аюулгүй аялаарай” зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх анхааруулга

Зуны саруудад, тэр тусмаа Үндэсний их баяр наадмын үеэр хүн бүр л агаар салхинд гарч амралт зугаалгаар явахаар тэмүүлдэг билээ. Энэ үеэр хөдөө орон нутгийг зорих, хотоос гадагш гарах авто тээврийн хөдөлгөөний тоо эрс нэмэгддэг. Хөдөө орон нутгийн замд хурд хэтрүүлэх, урсгал сөрөн гүйцэж түрүүлэх гэх зэрэг шалтгаанаас үүдэн гарсан ослоуд нь хот доторх ослоудаас хохирлын хэмжээгээрээ хэд дахин их байдаг.


Үндэсний эрсдэлийн индексээс харахад, зам тээврийн ослоор нас барсан хүмүүсийн 78 хувь нь хөдөө орон нутгийн замд гарсан ослоос болсон байдаг.

Тиймээс иргэдийн хөдөө орон нутгийг зорих нь идэвхэждэг зуны 7-р сард харилцагч нартаа болон олон нийтэд орон нутгийн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Аюулгүй аялаарай” анхааруулга мессежийг хүргэлээ.

- Судалгаанаас харахад, зам тээврийн ослын 97.5 хувь нь жолоочийн буруугаас үүдэлтэй байдаг. Тиймээс компанийн зүгээс хөдөө, орон нутгийг зорих гэж буй жолооч нарт зориулан аюулгүй аяллын зөвлөгөө хүргэсэн вебсайт www.naadam.mandal.mn-ийг ажиллуулан, бүрэн мэдээлэл авсан харилцагч нарыг шатахууны талоноор урамшуулж, аюулгүй аяллын гарын авлагыг тарааж сурталчлав.
- Зам тээврийн хөдөлгөөнд оролцохдоо жолооч болон зорчигч нарын аль аль нь сонор сэрэмжтэй байх нь чухал юм. Авто осолд өртсөн зорчигчдын 68 хувь нь хамгаалах бүсээ зүүгээгүй байсан нь тогтоогдсон байна.

Үүнээс харахад, зам тээврийн ослын талаар анхааруулгыг зөвхөн жолооч нарт зориулах биш зорчигчдод ч мөн хандах нь үр дүнтэй гэж үзэн, “Арын суудлын жолооч” хэмээх зөвлөгөө мэдээллийг сошиал хуудаснуудаар дамжуулан, аялал зугаалгын үеэр олон нийтэд хүргэсэн юм. Уг мэдээллүүдийг хүргэснээр зорчигчийн өөрийн амь нас, эрүүл мэндийг хамгаалж, жолоочид тавих хяналт сайжирч, зам тээврийн хөдөлгөөнд илүү сонор сэрэмжтэй оролцох хандлагыг нэмэгдүүлсэн юм.

Мандал даатгал нь цаашид ч мөн эрсдэлийг бууруулах чиглэлээр нийгмийн хариуцлагын бодлогоо баримталж ажиллах бөгөөд нийгэм дэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн аливаа төсөл хөтөлбөрүүдийг дэмжих тал дээр нээлттэй ажиллах болно.



MNDL ХУВЬЦАА

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Мандал даатгал 2018 оны 9-р сард МХБ-ээр дамжуулан IPO хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25 хувийг эзэмшүүлэн, 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт татав. Улмаар 2018 оны 12-р сарын 12-нд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компанийн дүрмийг шинэчлэн батлах зэрэг шийдвэр гаргалаа.


Мандал даатгалын хувьцаа нь MNDL симболтойгоор Монголын хөрөнгийн биржийн I ангилалд арилжаалагдаж байна. Мандал даатгалын хувьцаа олон нийтэд гараад удаагүй байгаа ч МХБ-ийн ТОП-20 индекст багтаж чадлаа.

Бид, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа улирал бүр цаг алдалгүй олон нийт, хөрөнгө оруулагчдадаа танилцуулж, хувьцаат компаниудын дунд жишиг тогтоон ажиллаж байна. Мөн хөрөнгийн зах зээлд оролцогчдын дунд Analyst call үйл ажиллагааг зохион байгуулж, институциональ хөрөнгө оруулагчийн үүргээ гүйцэтгэн, үйл ажиллагаагаа хөрөнгө оруулагчидтайгаа тогтмол холбоотойгоор явуулж байна.

Нийт хувьцааны тоо	6,243,016 ширхэг
Хаалтын ханш	5,250 ₮
Зах зээлийн үнэлгээ	32.8 тэрбум ₮
Нийт арилжааны дүн	1.9 тэрбум ₮
Өдрийн дундаж арилжааны дүн	28.2 сая ₮



EPS харьцаа	P/E харьцаа	ROA /нийт хөрөнгийн өгөөж/	ROE /өөрийн хөрөнгийн өгөөж/
620	8.5	14%	36%

A black and white photograph of a modern office interior. On the left, a call center area is visible with several employees at their desks. In the center, a man in a suit is walking. On the right, a lounge area features a large sofa and two people sitting on it. The ceiling has a grid of recessed lights, and there are large windows with decorative wooden slats. The floor is made of light-colored wood in a herringbone pattern.

МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

Корпорацын сайн засаглалын тэргүүн туршлагуудыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааг биелүүлэхэд чухал үүрэгтэй.

Компанийн засаглал нь компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа бөгөөд компанийн зорилгыг тодорхойлох, тэдгээр зорилгод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог хэрэгсэл юм. Корпорацын сайн засаглалын туршлагыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааны салшгүй хэсэг билээ.

Корпорацын сайн засаглал гэдэгт:

- Системтэй шийдвэр гаргах үйл явцтай байх,
- Хариуцлагын талаар ойлголт өгөх,
- Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх,
- Дотоод хяналтыг сайжруулах,
- Эрсдэлийн удирдлага,
- Ил тод байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа багтана.

Компанийн засаглалын тухайн хэсэгт Мандал даатгалын Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх үүрэг, хариуцлага, санхүүгийн тайлагналтай холбоотой компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар тусгалаа.

ЭРХ МЭДЭЛ, ХАРИУЦЛАГЫН ХУВААРИЛАЛТ

Компанийн хяналт болон удирдлага нь хувьцаа эзэмшигчид (Хувьцаа эзэмшигчдийн хурлаар), Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт гадаад зохицуулалт болон ТУЗ-өөс тогтоосон дотоод дүрэм, журмаар зохицуулагдан хуваарилагддаг.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Мандал даатгал компанийн эрх барих дээд байгууллага нь “Хувьцаа эзэмшигчдийн хурал” юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ногдол ашгийн бодлого тодорхойлох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах үүрэгтэй.

Мандал даатгал IPO гарган, нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 сарын 12-д Блю Скай зочид буудлын Кристал танхимд зарлан хуралдуулсан билээ. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан байна. Үүнд:

1. Компанийн хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбогдон гарсан зардлын тайланг танилцуулах;
2. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус шинэ гишүүдийг томилох;
3. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах зэрэг болно.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Мандал даатгал компанийн ТУЗ нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдал, эрүүл мэтгэлцээний соёлыг дэмжихийг зорьдог.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц

Мандал даатгал компанийн дүрэмд тусгагдсанаар ТУЗ нь 9 гишүүнтэй байхаас 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ.

Компанийн засаглалын кодексын дагуу ТУЗ-д аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хүнийг гишүүнээр сонгон ажиллуулахыг зөвлөсөн байдаг. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь компанийн үйл ажиллагаа, хөгжлийн үе шат болоод бусад нөхцөлтэй уялдсан байх шаардлагатай.

Мандал даатгал компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тодорхойлоход, зөвлөлийн үр ашигтай байдлыг хадгалах, дээшлүүлэх явдлыг ихээхэн анхаардаг.

2018 оны 12 сарын 12-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалтын үр дүнд үндэслэн, Мандал даатгал компанийн ТУЗ-ийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсон байна.

Ердийн гишүүнээр:

- Өлзийбаяр ГАНЗОРИГ
- Нямдаваа МОНСОП
- Очирпүрэв ГАНЖОЛОО
- Амартүвшин АМУНДРА
- Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ
- Батсайхан ЖАВХЛАН

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

- ЖЭЙМС Бернард Двайер
- Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН
- Нямандэлэг МАНДУУЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагаа

ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавин удирдан чиглүүлж ажилладаг. Жилийн төлөвлөгөө, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны хяналт, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалт, гүйцэтгэх удирдлага томилох зэрэг асуудал нь ТУЗ-өөр хянагдан, батлагддаг билээ.

ТУЗ нь санхүүгийн болон стратегийн бусад зорилт, бизнесийн гол сорилтууд, эрсдэл, бизнесийн хөгжил, хөрөнгө оруулагч, гадаад харилцааны гүйцэтгэлийн тайланг тогтмол хянах үүрэгтэй. Мөн компани нь ТУЗ-ийн гишүүдийг бүх түвшинд удирдлагуудтай чөлөөтэй, нээлттэй харилцах, холбогдох бүх мэдээлэлд хандах боломжоор ханган ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Засаглалын кодексыг хангах, ТУЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУЗ-ийн дэргэд туслах ажлын хэсгүүдийг байгуулан ажилладаг. ТУЗ-ийн хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон болно. Хороод нь улирал бүр тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнадаг.

Аудит, эрсдэлийн хороо

Мандал даатгал компанийн үйл ажиллагаа нь бүхэлдээ эрсдэлийг хэмжих, үнэлэх, удирдахтай холбоотой байдаг. Иймд ТУЗ дэргэдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, хянах үүрэгтэй "Аудит, эрсдэлийн хороо"-г ажиллуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хороо нь компанийн дотоод журам, тушаалын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянах үүрэгтэй.

Мөн компанийн дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын байгууллагын хоорондын харилцааг зохицуулах, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод, бүрэн бүтэн байдлыг шалгаж батлах, дотоод хяналтын системийг хянах, ТУЗ-д мэдэгдэх үүрэгтэй билээ.

Түүнчлэн компанийн нийт хүлээгдэж буй хариуцлага, түүнд харгалзах нөөцийн сан, эрсдэл даах чадварын шинжилгээтэй улирал бүр танилцаж, зохих заавар зөвлөмжийг гарган ажиллаж байна. Аудит, эрсдэлийн хороо нь 3 гишүүнтэй бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Аудит, эрсдэлийн хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Бернард Двайер даргалдаг.

Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, компанийн болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын асуудлыг зохицуулах бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх үүрэгтэй.

Засаглалын кодексын дагуу хорооны гишүүд нь компани болон удирдлагын багаас хараат бус байхыг шаарддаг бөгөөд хорооны бүрэлдэхүүн нь энэхүү дүрэмтэй бүрэн нийцэлтэй болно. Мандал даатгалын Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Өлзийбаяр ГАНЗОРИГ | ТУЗ-ийн дарга

Ө.Ганзориг санхүүгийн зах зээл дээр 20 орчим жил ажилласан туршлагатай. Тэрбээр даатгал, банк, хөрөнгийн захгаар дагнан мэргэшихдээ Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан мэргэжилтэн билээ.

Өнгөрсөн хугацаанд Голомт банк, Тэнгэр даатгал, Улаанбаатар хотын банк, Голомт капитал, Худалдаа Хөгжлийн банк, Хас банк, Капитрон банк зэрэг байгууллагуудад хариуцлагатай албан тушаал хашихаас гадна Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн гишүүн, Татварын ерөнхий газрын бодлогын зөвлөлийн гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны бодлогын зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн зөвлөлийн гишүүн, Монголын даатгагчдын холбооны дэд ерөнхийлөгч, Монголын банкуудын холбооны ерөнхийлөгчөөр тус тус сонгогдон ажиллаж иржээ.

Ө.Ганзориг нь Мандал даатгалын үүсгэн байгуулагч бөгөөд ТУЗ-ийн дарга юм. Мөн Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

Ө.Ганзориг нягтлан бодох бүртгэлийн бакалавр, санхүүгийн удирдлагын диплом, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Мөн Олон улсын санхүүгийн зах зээлийн холбооны дилерийн сертификатыг эзэмшдэг.



ЖЭЙМС БЕРНАРД ДВАЙЕР | ТУЗ-н хараат бус гишүүн

Жэймс Двайер нь Нью Йорк хотод хөрөнгө оруулалтын банкираар 30 гаруй жил ажилласан туршлагатай банкир юм. Тэрээр Shearson Loeb Rhoades болон UBS зэрэг дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкуудын M&A нэгжийг удирдан ажиллаж байжээ.

Двайер нь анх 2001 онд Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын асуудлаар Монголын Засгийн газрыг төлөөлөх хөрөнгө оруулалтын банкираар Монголд зочилж байсан бөгөөд Хаан банкны хувьчлалд хөрөнгө оруулалтын зөвлөхөөр мөн ажилласан байна. Тэрээр 2007-2016 онд Монголын Бизнесийн Зөвлөл /BCM/-ийг үүсгэн байгуулж, захирлын албан тушаалыг хашиж байв.

Жэймс Двайер Нотр Дамын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.



Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн багш, дэд профессороор ажилладаг. Тэрээр 1996 оноос хойш СЭЗИС-д багшлахын сацуу, олон тооны судалгаа шинжилгээ, эрдмийн бүтээл туурвиж, Монгол Улсын санхүүгийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм билээ.

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү банкны тэргүүний ажилтнаар тодорч байсан бөгөөд Монголын хөрөнгийн бирж, Монголын банкуудын холбоо, Санхүүгийн зохицуулах хороонд зөвлөхөөр сонгогдон ажиллаж байсан туршлагатай.

Ж.Дэлгэрсайхан нь Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн эдийн засгийн бакалавр, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн бакалавр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн удирдлагын магистрын зэрэгтэй.



Нямандэлэг МАНДУУЛ | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Н.Мандуул нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Үнэт цаас бүртгэлийн хэлтсийн даргаар ажилладаг.

Тэрээр Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт зөвлөх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Төсвийн бодлогын санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн даргаар тус тус ажилласан туршлагатай. Мөн 2016 онд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр томилогдон ажиллаж байсан.


Н.Мандуул нь Болгар улсын Америкийн Их Сургуулийг эдийн засаг, бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй, АНУ-ын Брэндиз Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгсгөсөн байна.



Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ | ТУЗ-ийн гишүүн

Ч.Ванчин-Эрдэнэ нь “Таван Богд Трейд” ХХК-ийн дэд захирлаар ажилладаг. Тэрээр, өмнө нь MCS Холдингид санхүүгийн шинжээч, “Скайтел” ХХК-д Санхүү төлөвлөлтийн хэлтэс хариуцсан захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Ч.Ванчин-Эрдэнэ нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсчээ.



Очирпүрэв ГАНЖОЛОО | ТУЗ-ийн гишүүн

О.Ганжолоо нь “Голомт Файнэншил Групп”-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр дэлхийн хамгийн том аудитын компани болох Price water house Coopers-н Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж ихээхэн туршлага хуримтлуулсан, туршлагатай мэргэжилтэн юм.

Мөн “Бодь Интернэшнл” ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал, Голомт банкны ТУЗ-ийн аудитын хорооны даргаар тус тус ажиллаж байв.

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуулийн эдийн засгийн магистр зэрэгтэй.



Амартүвшин АМУНДРА | ТУЗ-ийн гишүүн

А.Амундра нь хэвлэл мэдээллийн салбарын томоохон төлөөлөгчдийн нэг юм. Тэрээр эгнээндээ Eagle TV, Боловсрол ТВ зэрэг Монголын хамгийн олон үзэгчтэй телевизийн сувгуудыг багтаадаг Монгол Масс Медиа группийн гүйцэтгэх захирлаар 2010-2017 онуудад ажиллаж байв.

А.Амундра 2017 оноос эхлэн “Бодь Интернэшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Нямдаваа МОНСОР | ТУЗ-ийн гишүүн

Н.Монсор нь хил дамнасан хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр олон жилийн туршлага хуримтлуулсан туршлагатай санхүүч юм.

Тэрээр өнгөрсөн хугацаанд олон улсын томоохон хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын үл хөдлөх хөрөнгө, санхүү, худалдааны салбаруудад олон арван тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж чаджээ. Н.Монсор МҮХАҮТанхимын даргын зөвлөх хийж байсан бөгөөд одоо Юу Эм Си Группийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Н.Монсор нь Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн компьютер техник, менежментийн сургуулийг программ хангамжийн бакалавр зэрэгтэй төгсчээ.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Мандал даатгалын гүйцэтгэх захирал бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурлуудыг үр дүнтэй зохион байгуулахад ТУЗ-ийн даргатай нягт хамтран ажилладаг.

Мөн гүйцэтгэх захирал нь компани доторх дотоод хяналтын үр ашигтай тогтолцоог боловсруулж, хадгалж байх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаагаа ТУЗ-д тогтмол тайлагнадаг болно.

Удирдлагын хороо

Удирдлагын хороо нь компанийн үйл ажиллагааг сар, улирлаар хянах, гүйцэтгэлийн үр дүнг хэлэлцэх, компанитай холбоотой томоохон шийдвэрүүдийг гаргах, дотоод дүрэм, журам, хэм хэмжээг тогтоох үүрэгтэй.

Удирдлагын хороо нь өөрийн удирдлагад нөхөн төлбөрийн, дотоод хяналтын, хөрөнгө оруулалтын, байгууллагын соёл, ёс зүйн дэд хороодыг ажиллуулдаг.

Нөхөн төлбөрийн дэд хороо

Нөхөн төлбөр шийдвэрлэх процессын дагуу нөхөн төлбөрийн шийдвэр гаргах, процесс болон гэрээний андеррайтингийн нөхцөлүүдийг сайжруулахад чиглүүлэх, батлах зорилготой.

Дотоод хяналтын дэд хороо

Компанийн дотоод хяналтыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны процессын алдаа дутагдлыг засаж сайжруулах арга хэмжээг авах, дотоод хяналтын хэлтсийн үйл ажиллагааг чиглүүлэх зорилготой.

Хөрөнгө оруулалтын дэд хороо

Компанийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай санхүүгийн хэрэгслүүдэд байршуулж, хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын хяналт хийх, хөрөнгө оруулалт хийх хязгаар болон зорилтуудыг батлуулах зорилготой.

Байгууллагын соёл, ёс зүйн дэд хороо

Байгууллагын ёс зүйн кодексыг хэрэгжүүлэх, хянах, ёс зүйн гомдол санал шийдвэрлэх, хүний нөөцийн судалгаа, тоон мэдээлэлд суурилан, ажилтнуудын хандлагыг судалж сайжруулах, хэвшүүлэх ажлыг чиглүүлэх зорилготойгоор 2018 онд шинээр байгуулагдсан хороо юм.

УДИРДЛАГЫН БАГ



Б.Жавхлан
Гүйцэтгэх захирал

П.Оргодол
Үйл ажиллагаа
хариуцсан захирал

З.Одмаа
Маркетинг, бизнес хөгжил
хариуцсан захирал

Д.Нямрагчаа
Иргэдийн даатгал
хариуцсан захирал

Батсайхан ЖАВХЛАН | Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн

Б.Жавхлан Мандал даатгалын гүйцэтгэх захирал бөгөөд тус компанийн иргэдийн даатгалын газар, бизнес хөгжил болон эрсдэлийн удирдлагын газрыг хариуцан ажиллаж байсан, даатгалын салбарт 8 жил ажилласан туршлагатайгаас гадна мэдээлэл технологийн салбарт 2000 оноос хойш ажиллажээ. Мөн Япон Улсын Токио хотод мэдээлэл технологийн төслийн удирдагчаар 5 жил ажиллахдаа Японы зах зээлд хэд хэдэн амжилттай шийдэл нэвтрүүлсэн байна.

Б.Жавхлан нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг компьютерын ухааны бакалавр зэрэгтэй дүүргэжээ.

Дашдэндэв НЯМРАГЧАА | Иргэдийн даатгал хариуцсан захирал

Д.Нямрагчаа Мандал даатгалын Иргэдийн даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч бөгөөд иргэдийн даатгалын бизнес хөгжлийн алба, борлуулалтын алба, харилцагчийн халамж, нөхөн төлбөрийн албуудыг тус тус хариуцан ажиллаж байна.

Тэрээр, мэдээлэл технологийн чиглэлээр 6 жил, даатгалын чиглэлээр 7 жил ажилласан туршлагатай.

Д.Нямрагчаа нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг компьютерын ухааны бакалавр зэрэгтэй дүүргэжээ.

Зоригт ОДМАА | Маркетинг, бизнес хөгжил хариуцсан захирал

З.Одмаа Мандал даатгалын Бизнес хөгжил, маркетинг хариуцсан захирал бөгөөд компанийн бизнес хөгжил, маркетинг, брэндинг, олон нийтийн харилцааг хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарын маркетингийн чиглэлээр 9 жил ажилласан туршлагатай.

Түүнчлэн маркетингийн зөвлөх үйлчилгээний компанид Ерөнхий менежерээр ажиллаж, томоохон брэндингийн компанид ажлуудыг амжилттай удирдан хэрэгжүүлж байв.

З.Одмаа нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн удирдлагын магистр зэрэгтэй.

Пүрэвдорж ОРГОДОЛ | Үйл ажиллагаа хариуцсан захирал

П.Оргодол нь Мандал даатгалын Үйл ажиллагаа хариуцсан захирал бөгөөд тус компанийн санхүү, эрсдэл, захиргааны хэлтсүүдийг тус тус хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт санхүүгийн төлөвлөлт, эрсдэлийн шинжилгээ, дотоод хяналтын чиглэлээр 4 жил ажилласан туршлагатай.

П.Оргодол нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийг эдийн засгийн бакалавр зэрэгтэй дүүргэжээ.



АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Хараат бус аудиторын дүгнэлт

"Мандал даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Мандал даатгал" ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, "Мандал даатгал" ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.



Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Компани нь 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даатгалын байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг баримталж санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.


Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Төлбөрийн чадварын талаар

Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 150.62% (2017: 109.82%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэсний дагуу зохистой байна.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Б. ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР
АУДИТ ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
2019 оны 3 дугаар сарын 19

Н. ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөгөөр	Тодруулга	2017	2018
Хөрөнгө			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4 1,805,207	3,082,303
	Даатгалын авлага	5 4,402,449	4,816,979
	Бусад санхүүгийн хөрөнгө	6 401,174	303,965
	Бусад санхүүгийн бус хөрөнгө	7 182,385	1,233,157
	Хөрөнгө оруулалт	8 9,229,438	19,837,291
	Даатгалын хөрөнгө	9 4,868,576	3,888,840
	Үндсэн хөрөнгө	10 288,956	351,967
	Биет бус хөрөнгө	11 57,325	33,147
	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	12 236,640	236,640
	Нийт хөрөнгө	21,472,150	33,784,289
Өр төлбөр ба эзэмшигчийн өмч			
	Өр төлбөр		
	Даатгалын өглөг	13 2,055,456	1,065,374
	Бусад санхүүгийн бус өр төлбөр	14 1,138,865	645,614
	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	15 9,366,278	13,115,353
	Нөхөн төлбөрийн нөөц сан	16 2,910,659	3,383,397
	Нийт өр төлбөрийн дүн	15,471,258	18,209,738
	Эздийн өмч		
	Хувьцаат капитал	6,243,016	6,243,016
	Халаасны хувьцаа	(1,243,016)	-
	Нэмж төлөгдсөн капитал	-	4,441,896
	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	20,490
	Хуримтлагдсан ашиг	1,000,892	4,869,149
	Нийт эздийн өмчийн дүн	6,000,892	15,574,551
	Нийт өмч ба өр төлбөр	21,472,150	33,784,289

Уг санхүүгийн тайланг 2019 оны 3 дугаар сарын 19-д батлав.

Энэхүү санхүү байдлын тайланг 69-аас 89 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр	Тодруулга	2017	2018
Даатгалын хураамжийн нийт орлого	18	22,533,093	27,786,499
Даатгалын хураамжийн буцаалт	18	(1,207,753)	(1,529,982)
Давхар даатгалын хураамжийн зардал	18	(11,243,874)	(9,807,090)
Даатгалын хураамжийн цэвэр орлого		10,081,466	16,449,427
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	18	(1,893,215)	(3,749,075)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	18	(1,145,087)	(768,662)
Орлогод тооцсон хураамж		7,043,164	11,931,690
Нийт нөхөн төлбөрийн зардал	18	(4,705,634)	(4,324,094)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	18	2,533,555	790,080
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	18	97,611	247,954
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		(2,074,468)	(3,286,060)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	18	(444,324)	(424,881)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	18	379,999	(166,407)
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	18	(242,532)	(47,858)
Зардалд тооцсон нөхөн төлбөр		(2,381,325)	(3,925,206)
Даатгалын гэрээний зардал	19	(1,203,701)	(1,315,776)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	20	925,392	438,772
Хөрөнгө оруулалтын орлого	21	1,226,959	2,248,376
Даатгалын үйл ажиллагааны ашиг		5,610,489	9,377,856
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		28,145	28,082
Бусад орлого		62,809	74,650

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(үргэлжлэл)

мянган төгрөгөөр	Тодруулга	2017	2018
Ерөнхий ба удирдлагын зардал	22	(3,522,843)	(3,986,955)
Борлуулалт, маркетингийн зардал	23	(517,291)	(608,100)
Бусад зардал	24	(416,597)	(555,127)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз		28,366	81,781
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз		(8,004)	(38,566)
Бусад алдагдал		(4,345,415)	(5,004,235)
Татвар төлөхийн өмнөх ашиг (19+27)		1,265,074	4,373,621
Орлогын татварын зардал	25	(162,548)	(505,364)
Татварын дараах ашиг		1,102,526	3,868,257
Бусад дэлгэрэнгүй орлого			
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл		-	20,490
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		1,102,526	3,888,747
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		0.177	0.623

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг 69-аас 89 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	Нийт
2017.01.01-ний байдлаар	6,243,016	(1,243,016)	-	-	(101,634)	4,898,366
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	1,102,526	1,102,526
2017.12.31-ний байдлаар	6,243,016	(1,243,016)	-	-	1,000,892	6,000,892
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	3,868,257	3,868,257
Өмчид гарсан өөрчлөлт	-	1,243,016	4,441,896	-	-	5,684,912
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	20,490	-	20,490
2018.12.31-ний байдлаар	6,243,016	-	4,441,896	20,490	4,869,149	15,574,551

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг 69-аас 89 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр	2017	2018
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Даатгалын хураамжийн орлого	19,064,203	21,581,831
Давхар даатгалын нөхөн төлбөр	65,639	243,513
Бусад мөнгөн орлого	65,392	2,663,208
Ажиллагчдад төлсөн	(1,443,129)	(2,094,710)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(366,876)	(465,100)
Бараа материал худалдан авахад төлсөн	(15,928)	(4,153)
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	(9,586,830)	(10,060,111)
Нөхөн төлбөрт төлсөн	(3,955,257)	(4,245,308)
Үүнээс: Сайн дурын даатгалын	(2,496,255)	(3,501,883)
Албан журмын даатгалын	(1,459,002)	(743,425)
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	(80,567)	(96,165)
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	(426,213)	(496,281)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(79,496)	(69,167)
Татварын байгууллагад төлсөн	(263,286)	(865,300)
Даатгалын төлбөрт төлсөн	(955)	(1,957)
Бусад мөнгөн зарлага	(1,617,975)	(3,036,745)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,358,722	3,053,555
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	31,365
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	4,229,569	6,181,039
Хүлээн авсан хүүний орлого	591,315	2,012,377
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(54,425)	(115,761)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(8,039,530)	(15,862,327)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,273,070)	(7,753,307)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	5,976,848
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	5,976,848
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,914,348)	1,277,096
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,719,555	1,805,207
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,805,207	3,082,303

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг 69-аас 89 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Компани нь 2011 оны 4 дүгээр сарын 26-нд “Мандал Женерал” ХХК нэртэйгээр Монгол улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 146 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын үйл ажиллагаа” эрхлэх тусгай зөвшөөрлийг авсны дараа албан ёсны нэрээ “Мандал Женерал Даатгал” ХХК болгон өөрчилж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх болсон байна. 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр “Мандал даатгал” гэж нэрээ өөрчилсөн.

Компани нь 2018 онд нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээл дээр арилжаалж, 2018 оны 9 дүгээр сарын 21-нд хувьцаат компанийн хэлбэрт шилжин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн. Тодруулга 31.1-с хувьцаа эзэмшил, хяналтын харилцааны талаарх мэдээллийн дэлгэрэнгүйг харна уу.

Үйл ажиллагааны чиглэл: Ердийн даатгалын үйл ажиллагааны хүрээнд Гэнэтийн осол, эмчилгээний зардлын, Хөрөнгийн, Авто тээврийн хэрэгслийн, Барилга угсралтын, Ачааны, Агаарын хөлгийн, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын, Газар тариалангийн, Мал амьтдын, Хариуцлагын, Санхүүгийн, Зээлийн, Итгэлцлийн, Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн, Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын зэрэг даатгалын төрөл байна.

Компанийн хүний нөөц: Компанийн ажилтнуудын дундаж тоо 2018 оны туршид 105 (2017 онд: 100) байсан.

Бүртгэгдсэн хаяг: Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Паркплейс Оффис” барилгын 1, 3, 5 дугаар давхруудад байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани одоогоор 17 хэлбэрийн даатгалын үйл ажиллагаа эрхлэн, 3 салбартайгаар ажиллаж байна.

2. Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

2.1 Үндсэн зарчим

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (“СТОУС”)–д нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэв.

2.2 Хэмжилтийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн тодорхой санхүүгийн хэрэглүүрээс бусдаар түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиромжтой илэрхийлж байгаа учраас төгрөг нь уг Компанийн үйл ажиллагааны валют юм.

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр санхүүгийн тайлангуудыг (өөрөөр заагаагүй бол) Монгол төгрөгөөр толилуулна. Монгол төгрөгөөр илэрхийлсэн санхүүгийн бүх мэдээлэл мянган төгрөгөөр бүхэлтгэн илэрхийлэгдсэн.

2.4 Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь удирдлагаас санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дүн болон тайлант хугацааны орлого, зарлагын тайлагнасан дүнд нөлөөлөх чухал таамаглал тооцоолол хийхийг шаарддаг.

Эдгээр тооцоолол нь тухайн үйл явдал, үйл ажиллагааны талаарх удирдлагын хамгийн сайн мэдлэг дээр суурилсан байдаг боловч, бодит үр дүн нь эцсийн дүндээ эдгээр тооцооллоос өөр байж болох бөгөөд анхны тооцоолол, түүний таамаглалыг тухайн нөхцөл байдал, тухайн жилд нь тохируулан өөрчилж болно.

Даатгалын нөөц сангийн тооцоолол

Компанийн актуарч нь Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын дагуу даатгалын хураамжийн нөөц болон даатгалын нэхэмжлэлийн нөөц сангуудыг тооцоолдог.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг (ОТХН) даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд “хувь тэнцүүлсэн арга”-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг (УБМХНС) даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистик тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд (МБТХНС) тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, и-мэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг (УБХНС) даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

3.1 Гадаад валют

Гадаад валютаарх ажил гүйлгээ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа

бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам.доллартай харьцах ханш 2,642.92 төгрөг (2017 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,427.13 төгрөг) байв. Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана.

3.2 Даатгалын хөрөнгө

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр УБМХНС болон МБТХНС-ийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр бүртгэдэг.

Давхар даатгалын хойшлогдсон хураамж нь давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг юм.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлийг давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцдог.

Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал нь даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлын тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг байдаг.

Тухайлбал зуучлагч болон төлөөлөгчийн даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал, даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан даатгалын гэрээний хойшлогдсон бусад зардлаас бүрддэг.

3.3 Даатгалын бүтээгдэхүүн

Компани нь ердийн даатгалын бүх нийтлэг хэлбэрийг хамарсан даатгалын бүтээгдэхүүнүүд санал болгодог. Компанийн үндсэн бүтээгдэхүүний хэлбэрүүд нь:

- Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал,
- Хөрөнгийн даатгал,
- Барилга угсралтын даатгал,
- Ачааны даатгал,
- Тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгал,
- Хариуцлагын даатгал,
- Санхүүгийн даатгал,
- Зээлийн даатгал гэх мэт байна.

3.4 Даатгалын нөөц сан

Нөөц сан нь Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)-уудаас бүрдэнэ.

ОТХН-д даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсэг ордог.

УБМХНС-г тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнгээр хэмждэг.

УБХНС-г тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сангаар хэмждэг.

3.5 Үндсэн хөрөнгө

Ажил үйлчилгээний зорилгоор ашиглаж буй машин, тоног төхөөрөмж, компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дараа үеийн хуримтлагдсан элэгдэл болон хорогдуулгыг хассан дүнгээр тайлагнана.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Тусад нь бүртгэсэн үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг солих зардлыг уг данснаас хассан бүрэлдэхүүн хэсгийн дансны үнээр капиталжуулна. Бусад дараа үеийн зардал ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр бол капиталжуулна. Засвар үйлчилгээ гэх мэт бусад бүх зардлыг үүссэн дүнгээр нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Автомашин	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	- 3 жил
Бусад	- 10 жил

3.6 Биет бус хөрөнгө

Компани худалдан авсан хязгаарлагдмал ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдлыг хассан дүнгээр тайлагнана.

Хорогдлыг биет бус хөрөнгийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгах ба биет бус хөрөнгийн ашиглах хугацаа 3 жил байна.

3.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Түрээсийн орлого олох болон капиталын үнийг өсгөх зорилгоор эзэмшиж буй хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тээврийн зардлыг багтаасан өртгөөр анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа бодит үнэ цэнээр хэмждэг.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тухайн үүссэн үеийн ашиг алдагдалд хамруулна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс олсон түрээсийн орлого болон үйл ажиллагааны зардлыг орлого, бусад зардлаар тус тус бүртгэнэ.

3.8 Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхны хэмжилт

СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр хэмждэг дансны авлагаас бусад санхүүгийн хөрөнгийг анх бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд илэрхийлэх санхүүгийн хөрөнгө
- Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ

Санхүүгийн хөрөнгүүдээ дараах зүйлсийг харгалзан үзэж, ангилна:

- Санхүүгийн хөрөнгийг удирдах тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээнд тусгасан мөнгөн урсгалын шинж чанар.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Санхүүгийн хэрэглүүрийн ангилал нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай.

I. Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгө

Дараах нөхцөлүүд зэрэг биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ:

- Санхүүгийн хөрөнгө нь 'гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших' бизнесийн загварт хамаарах,
- Санхүүгийн хөрөнгө нь SPPI буюу хүү ба үндсэн төлбөрийн төстийн шалгуурыг хангасан.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараагаар эдгээрийг хорогдуулсан өртгөөр үр ашигт хүүгийн аргыг ашиглан хэмжинэ. Дискаунтчилсан дүн нь материаллаг бус бол орхигдуулж болно. Компанийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, дансны болон ихэнх бусад авлага нь санхүүгийн хэрэглүүрийн уг ангилалд хамаарах бөгөөд өмнө нь НББОУС 39-ын дагуу хугацааны эцэс хүртэл эзэмших ангилалд бүртгэгдсэн үнэт цаасыг мөн уг ангилалд хамруулна.

II. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өртөг эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж, ангилах шаардлагад нийцэхгүй байгаа санхүүгийн хөрөнгүүдийг ашиг эсвэл алдагдалаарх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Түүнчлэн SPPI буюу хүү ба үндсэн төлбөрийн төстийг хангахгүй санхүүгийн хөрөнгийг түүний бизнесийн загвараас үл хамааран уг ангилалд бүртгэнэ. Өмчийн хэрэглүүрийг уг ангилалд хамруулна.

III. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө

Дараах нөхцөлүүд зэрэг биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ:

- Хөрөнгө нь 'цуглуулах мөн борлуулахаар эзэмших' бизнесийн загварт хамаардаг болон
- Санхүүгийн хөрөнгө нь SPPI буюу хүү ба үндсэн төлбөрийн төстийн шалгуурыг хангасан. Компани ерөнхийдөө бүх санхүүгийн хөрөнгөө төлбөр тооцоо хийх өдрийн бүртгэлээр хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаарх үнэлгээг ядаж тайлант хугацааны эцэс бүрт хийнэ.

Дансны ба бусад авлага

Эргэлтийн дансны авлагыг бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Харин дараа үед хорогдсон өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр хэмжинэ. Дансны авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийг Компани уг авлагыг анхдагч нөхцлийн дагуу бүгдийг цуглуулах боломжгүй болсон гэсэн бодит нотолгоотой болсон үед байгуулна. Зээлдэгчид учирсан санхүүгийн томоохон бэрхшээл, гэрээ үл биелүүлэх болон төлөлт удаашрах зэрэг нь уг дансны авлагын үнэ цэнэ буурсныг илтгэнэ. Нөөцийн дүн нь хөрөнгийн дансны үнэ болон анхдагч үр ашигт хүүний түвшингээр дискаунтчилсан ирээдүйд орохоор тооцоолсон мөнгөн гүйлгээ хоорондын зөрүү юм.

Авлагын хасагдуулгын үлдэгдлийг тайлант хугацааны ашиг, алдагдалд тусгасан төлбөр эсвэл орлогыг бүртгэж тохируулна. Харилцагчийн дансны үлдэгдэлтэй холбоотой данснаас хассан аливаа дүнг өмнө нь байсан найдваргүй авлагын хасагдуулгаас хасна. Цуглуулах боломжгүй гэж үзсэн бүх дансны авлагыг данснаас хасна.

Бэлэн мөнгө ба банкн дахь үлдэгдэл

Компанийн бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкн дахь дансд болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг багтаасан Дансны ба бусад өглөг орно. Компанийн санхүүгийн өр төлбөрийн төрөлжүүлсэн хураангуйг тодруулга 21.2-д харуулав.

I. Зээл ба зээллэг

Зээл ба зээллэгийг зээллэгтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг болон үр ашигт хүүгийн сууриарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

II. Дансны ба бусад өглөг

Дансны ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

3.9 Өмч

Компанийн гаргасан өмчийн хэрэглүүрийг хүлээж авсан орлогоор бүртгэнэ. Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ. Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно. Хуримтлагдсан ашигт тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг багтана.

Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

3.10 Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

3.11 Орлогын хүлээн зөвшөөрөлт

Орлого нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг хамаарна.

Даатгалын бус орлого, олзод түрээсийн орлого, үйл ажиллагааны бусад орлого, үйл ажиллагааны бус бусад олз, гарз багтана.

Орлогыг дараах нөхцөл бүрдсэнээр хүлээн зөвшөөрнө.

- Орлогын дүнг бодитой тооцон гаргах боломжтой,
- Ажил гүйлгээний эцсийн өгөөжийг хүртэх магадлалтай байх

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг багтдаг.

Даатгалын гэрээний үндсэн дээр даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг Даатгалын хураамжийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулсны төлөө давхар даатгагчаас төлөх шимтгэлийг Давхар даатгалын шимтгэлийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгалын гэрээний дагуу давхар даатгагчаас авсан буюу авахаар тохиролцсон даатгалын нөхөн төлбөрийг Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Даатгалын зүйлд даатгалын эрсдэл тохиолдож даатгагчаас нөхөн төлбөрийг даатгуулагчид төлсөн бөгөөд тухайн нөхөн төлбөрийн зарим хэсгийг эсвэл бүхэлд нь буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн хэмжээг Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Нөөц сангийн хөрөнгө, дүрмийн сангийн хөрөнгө болон тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан сул чөлөөтэй хөрөнгийг арвижуулах зорилгоор байршуулснаар олсон орлого, олзыг Хөрөнгө оруулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

3.12 Даатгалын зардал

Давхар даатгалын хураамж нь давхар даатгалын гэрээний үндсэн дээр даатгагч өөрийн даатгалын эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсний төлөө төлөх төлбөр байна.

Даатгалын хураамжийн буцаалт нь даатгалын гэрээ цуцлагдахад гэрээний үлдэх хугацаанд ногдох хураамжаас гэрээнд заасны дагуу даатгуулагчид өгөх даатгалын хураамж байна.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт нь ОТХНөөцийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. ОТХНөөцийг нэмж байгуулах үед зардал, бууруулж байгуулах үед орлого утгатай байна.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт нь Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Нөхөн төлбөрийн зардал гэж даатгалын зүйлд даатгалын гэрээнд заасан эрсдэл тохиолдож даатгагчаас хохирлыг барагдуулахаар олгож буй төлбөр байна.

Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт нь УБМХНС болон МБТХНСанг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Нөхөн төлбөрийн нөөцийн Давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт нь УБМХНС болон МБТХНСангийн давхар даатгагчид ногдох хэсгийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Даатгалын нөөцийн Давхар даатгагчид ногдох УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт нь УБХНСанг байгуулахад зориулсан зардлын данс байна.

Даатгалын гэрээний зардал гэж даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан зардал байна.

3.13 Нэгж хувьцаанд ноогдох ашиг

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

мянган төгрөгөөр	2017	2018
Бэлэн мөнгө	10,353	4,505
Банкан дахь харилцах данс	817,936	1,855,965
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	870,899	1,221,833
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	106,019	-
Нийт	1,805,207	3,082,303

5. Даатгалын авлага

мянган төгрөгөөр	2017	2018
Даатгалын хураамжийн авлага	2,529,442	4,207,657
Буруутай этгээдээс авах авлага	91,092	215,791
Давхар даатгалаас авах авлага	1,781,915	393,531
Нийт	4,402,449	4,816,979

Эдгээр авлагын насжилтын шинжилгээг дор харуулав:

мянган төгрөгөөр	2017	2018
Хэвийн /30 хүртэл хоног/	2,652,602	4,734,520
Хугацаа хэтэрсэн /31-60 хоног/	1,236,768	43,420
Хэвийн бус /61-90 хоног/	158,841	7,090
Эргэлзээтэй /91-120 хоног/	-	4,825
Муу /121-ээс дээш хоног/	354,238	27,124
Нийт	4,402,449	4,816,979

“Мандал даатгал” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо эргэлзээтэй авлагыг найдваргүй нь тодорхой болсон үед авлагын данснаас шууд хасах бодлого баримталдаг ба тайлант хугацаанд 544,702 мянган төгрөгийн (2017: 376,369 мянган төгрөг) авлагыг данснаас хассан байна.

6. Бусад санхүүгийн хөрөнгө

мянган төгрөгөөр	2017	2018
Бусад байгууллагаас авах авлага	388,312	294,720
Холбоотой талаас авах авлага	12,862	9,245
Нийт	401,174	303,965

7. Бусад санхүүгийн бус хөрөнгө

мянган төгрөгөөр	2017	2018
Нийгмийн даатгалын шимтгэл болон бусад татварын авлага	31,980	46,171
Бараа материал	21,928	23,543
Урьдчилж төлсөн зардал	128,477	1,163,443
Нийт	182,385	1,233,157

8. Хөрөнгө оруулалт

мянган төгрөгөөр	2017	2018
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө оруулалт	8,416,710	15,859,210
Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт	812,728	3,978,081
Нийт	9,229,438	19,837,291

Үнэт цаасаар хөрөнгө оруулалт нь Засгийн газрын бонд, компанийн бондууд болон компанийн хувьцаа байна.

9. Даатгалын хөрөнгө

мянган төгрөгөөр	2017	2018
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	3,625,756	2,857,095
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг - УБМХНС*	179,442	225,454
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг - МБТХНС**	535,186	322,767
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал - Даатгалын зуучлагч	34,779	20,800
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал - Даатгалын төлөөлөгч	493,413	462,724
Нийт	4,868,576	3,888,840

*УБМХНС - Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн сан

**МБТХНС - Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөцийн сан

10. Үндсэн хөрөнгө

мянган төгрөгөөр	Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
Өртөг					
2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	172,509	159,659	224,601	20,805	577,574
Нэмэгдсэн	3,552	8,865	48,868	24,348	85,633
Хасагдсан	(21,624)	(132)	(5,258)	-	(27,014)
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	154,437	168,392	268,211	45,153	636,193
Нэмэгдсэн	78,585	65,272	66,702	11,674	222,233
Хасагдсан	(125,304)	(42,830)	(4,548)	(6,574)	(179,256)
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	107,718	190,834	330,365	50,253	679,170
Хуримтлагдсан элэгдэл					
2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	68,044	47,491	165,282	3,039	283,856
Байгуулсан элэгдэл	15,931	16,428	41,576	3,353	77,288
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	(10,610)	(63)	(3,234)	-	(13,907)
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	73,365	63,856	203,624	6,392	347,237
Байгуулсан элэгдэл	15,877	16,034	43,835	4,464	80,210
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	(74,596)	(19,336)	(3,294)	(3,018)	(100,244)

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	14,646	60,554	244,165	7,838	327,203
Үлдэгдэл өртөг					
Эхний үлдэгдэл	81,072	104,536	64,587	38,761	288,956
Эцсийн үлдэгдэл	93,072	130,280	86,200	42,415	351,967

Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгө байхгүй байна.

2018 онд 222,233 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (2017: 85,633 мянган төгрөг) худалдан авсан байна.

Элэгдлийн зардлыг Орлогын дэлгэрэнгүй тайлангийн Ерөнхий ба удирдлагын зардалд тусгадаг.

11. Биет бус хөрөнгө

мянган төгрөгөөр	Компьютерийн програм хангамж	Нийт
Өртөг		
2017 оны 1 дүгээр сарын 1-ээрх	155,250	155,250
Нэмэгдсэн	-	-
Хасагдсан	-	-
2017.12.31	155,250	155,250
Нэмэгдсэн	37,000	37,000
Хасагдсан	-	-
2018 оны 12 дугаар сарын 31-ээрх	192,250	192,250
Хуримтлагдсан хорогдуулга		
2017 оны 1 дүгээр сарын 1-ээрх	49,907	49,907
Байгуулсан хорогдуулга	48,018	48,018
Данснаас хасагдсан	-	-
2017.12.31	97,925	97,925
Байгуулсан хорогдуулга	61,178	61,178
Данснаас хасагдсан	-	-
2018 оны 12 дугаар сарын 31-ээрх	159,103	159,103
Үлдэгдэл өртөг		
Эхний үлдэгдэл	57,325	57,325
Эцсийн үлдэгдэл	33,147	33,147

Хорогдуулгын зардлыг Ерөнхий ба удирдлагын зардалд тусгадаг.

12. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

мянган төгрөгөөр	2017	2018
Бодит үнэ цэнэ		
Эхний үлдэгдэл	236,640	236,640
Бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн цэвэр олз	-	-
Эцсийн үлдэгдэл	236,640	236,640

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ материаллаг хэмжээгээр өөрчлөгдөөгүй гэж Компанийн удирдлага үзсэн тул дахин үнэлгээ хийлгээгүй байна.

13. Даатгалын өглөг

мянган төгрөгөөр	2017	2018
Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	2,143	6,104
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	35,257	106,194
Давхар даатгагчид өгөх өглөг	2,018,056	953,076
Нийт	2,055,456	1,065,374

14. Бусад санхүүгийн бус өр төлбөр

мянган төгрөгөөр	2017	2018
Орлогын татварын өглөг	66,396	-
Цалингийн өглөг	231,815	215,388
Бусад өглөг	126,209	178,861
НДШ-ийн өглөг	-	8,514
Урьдчилж орсон орлого	714,445	242,851
Нийт	1,138,865	645,614

15. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц

мянган төгрөгөөр	2017	2018
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2,492,306	5,930,927
Хөрөнгийн даатгал	1,807,795	1,591,912
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,996,202	2,455,450
Ачааны даатгал	28,844	4,580
Барилга угсралтын даатгал	590,645	254,436

Агаарын хөлгийн даатгал	-	261,402
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	36,159	82,173
Хариуцлагын даатгал	1,819,171	1,866,107
Санхүүгийн даатгал	174,915	178,601
Итгэлцлийн даатгал	410	-
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	-	3,659
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	-	265,510
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	419,831	220,596
Нийт	9,366,278	13,115,353

Актурчийн нөөц сангийн тооцооллын тайланд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг 2018 оны 12 дугаар 31-ний өдрийн байдлаар хүчинтэй байгаа бүх даатгалын гэрээний хураамжийн орлогыг тухайн гэрээний үргэлжлэх хугацаанд хувь тэнцүүлэх замаар тооцоолсон. Хүчинтэй даатгалын гэрээнд үндэслэн тооцоолол хийхэд нийт 13,115,353 мянган төгрөг (2017: онд 9,366,278 мянган төгрөг)-ийн нөөц сан байгуулагдсан. Үүнээс "Мандал Даатгал" ХК-д харгалзах орлогод тооцоогүй хураамжийн дүн нь 10,258,257 мянган төгрөг (2017: онд 5,740,522 мянган төгрөг) байсан.

16. Нөхөн төлбөрийн нөөц сан

мянган төгрөгөөр	2017	2018
Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	334,326	740,952
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	702,229	720,484
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	617,814	665,671
Тусгай нөөц сан	1,256,290	1,256,290
Нийт	2,910,659	3,383,397

Актурчийн нөөц сангийн тооцооллын тайланд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг 2012 оны 2-р улирлаас хойших компанийн төлсөн нийт нөхөн төлбөрийн өгөгдөл дээр үндэслэн Гурвалжингийн аргаар даатгалын бүтээгдэхүүн бүрээр байгуулсан. Зарим бүтээгдэхүүн дээр гурвалжингийн аргаар байгуулахад тоон мэдээлэл хангалтгүй буюу нөхөн төлбөрийн тоо ширхэг цөөн үед хохирлын харьцааны аргаар энэ нөөцийг тооцоолсон.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг тооцоходоо 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлөгдөж амжаагүй болон системд бүртгэлтэй нийт нөхөн төлбөрийн дүнд үндэслэн тус нөөц сангийн жагсаалтыг байгуулсан. Нийт 720,484 мянган төгрөг (2017 онд: 702,229 мянган төгрөг)-ийн нөөц байгуулагдсан байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг байгуулахад журмын 8.2-р заасан томъёог ашиглан даатгалын хэлбэр тус бүрээр тооцоолсон. Тайлант улиралд харгалзах компанийн нийт орлогод тооцсон хураамж, цэвэр нөхөн төлбөр, НТ-ийн нөөц сангийн өөрчлөлт, үйл ажиллагааны зардал зэрэгт үндэслэн тооцоолоход учирч болзошгүй хохирлын нөөц сангийн үлдэгдэл дүн нь 665,671 мянган төгрөг (2017 онд: 617,814 мянган төгрөг)-өөр байгуулагдсан.

17. Эздийн өмч

17.1 Хувьцаат капитал

мянган төгрөгөөр	2017	2018
Зарласан хувьцааны тоо /ширхэгээр/	6,243,016	6,243,016
Эргэлтэд байгаа энгийн хувьцааны тоо /ширхэгээр/	5,000,000	6,243,016
Халаасны хувьцаа тоо	1,243,016	-
Гаргасан халаасны хувьцааны тоо /ширхэгээр/	-	1,243,016
Нэгж энгийн хувьцааны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	1,000	1,000
Нийт хувьцаат капиталын дүн /мянган төгрөгөөр/	5,000,000	6,243,016

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

18. Даатгалын үйл ажиллагааны орлого, зардал

	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого	Орлогд тооцогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	Хойшуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	Орлогд тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Нөхөн төлбөрийн цэвэр зардал	Нөхөн төлбөрийн нөөцийн сагсийн өөрчлөлт	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгал-д ногдох хэсгийн өөрчлөлт	Учирч болошгүй хохирлын нөхцөл сагсийн өөрчлөлт	Зардалд тооцсон нөхөн төлбөр	Даатгалын гэрээний зардал
Генерийн осол, Энхилгээний зардлын даатгал	8,593,829	289,173	490,485	7,814,170	3,438,623	(144,543)	4,231,005	1,387,903	1,017,659	205,127	(8,465)	-	1,214,300	327,176
Хөрөнгийн даатгал	4,124,849	524,325	1,486,956	2,113,568	(215,883)	(273,727)	2,055,724	175,074	85,366	20,417	(43,798)	(896,520)	(634,535)	367,124
Автозаврийн хэрэгслийн даатгал	4,870,190	573,181	(52,159)	4,149,167	459,247	(169,285)	3,520,635	1,961,435	1,639,866	122,984	23,799	116,283	1,903,003	346,108
Ачааны даатгал	112,188	888	16,450	94,850	(24,264)	(2,731)	116,382	33,425	8,826	106,149	(23,075)	1,519	93,419	721
Барилга усралтын даатгал	5,842,080	613	5,834,530	6,917	-336,209	(327,627)	15,500	-	-	143,206	(106,299)	471,079	507,985	5,681
Агаарын хөлийн даатгал	610,188	-	564,568	45,591	261,402	242,039	26,227	-	-	1,296	-	-	1,296	-
Автозаврийн хэрэгслийн жолоочийн харууцлагын даатгал	121,515	685	-	120,850	46,014	(3,237)	71,599	-	-	1,165	418	(6,006)	(4,423)	112,643
Хархицлагын даатгал	2,231,006	44,237	732,069	1,454,700	46,936	(239,459)	1,168,304	161,039	32,102	(178,489)	297,903	-	151,517	120,178
Санхүүгийн даатгал	266,289	-	140,729	127,539	3,685	(9,823)	114,031	-	-	5	-	-	5	26,827
Зөвлөлийн даатгал	-	-	-	-	-	-	100,704	83,738	83,738	46,467	277	(36,259)	130,472	-
Итгэлцлийн даатгал	-	-	-	-	410	-	410	-	-	(17)	-	-	(36,276)	-
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	51,371	-	12,843	38,528	3,659	915	35,784	-	-	1,636	-	-	1,636	-
Төмөр замын эсрэг усан замын тээврийн хэрэгслийн өмчлөх зэмшиг шилжлэлийн холбоотой харууцлагын даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	3,272
Агаарын хөлийн өмчлөх зэмшиг шилжлэлийн холбоотой харууцлагын даатгал	616,469	-	601,751	14,719	285,510	259,287	8,496	-	-	1,309	-	-	1,309	6,146
Жолоочийн харууцлагын албан журмын даатгал	544,595	96,900	(21,132)	468,828	(199,235)	(100,471)	567,593	504,514	418,403	(46,314)	25,647	(102,238)	295,488	-
2018 оны нийт дүн	27,786,499	1,529,982	9,807,090	16,449,427	3,749,075	(768,662)	11,931,690	4,324,094	3,286,060	424,881	166,407	47,659	3,925,206	1,315,776

18. Даатгалын үйл ажиллагааны орлого, зардал (үргэлжлэл)

	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого	Орлогд тооцогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	Хойшуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	Орлогд тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Нөхөн төлбөрийн цэвэр зардал	Нөхөн төлбөрийн нөөцийн сагсийн өөрчлөлт	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгал-д ногдох хэсгийн өөрчлөлт	Учирч болошгүй хохирлын нөхцөл сагсийн өөрчлөлт	Зардалд тооцсон нөхөн төлбөр	Даатгалын гэрээний зардал
Генерийн осол, Энхилгээний зардлын даатгал	4,943,509	162,586	875,641	3,905,284	1,421,895	(196,978)	2,286,411	648,742	311,793	30,196	15,383	283,396	643,750	131,919
Хөрөнгийн даатгал	3,532,545	80,444	2,121,231	1,330,870	225,434	(166,043)	941,393	253,414	86,218	(3,301)	32,884	(78,059)	37,743	168,527
Автозаврийн хэрэгслийн даатгал	3,672,701	531,479	425,470	2,715,752	519,800	(473,887)	1,722,065	1,763,415	824,465	(30,829)	24,583	-	818,218	187,328
Ачааны даатгал	118,553	10,144	23,351	85,057	(36,820)	(19,820)	101,968	-	-	5,750	(274)	2,342	7,817	16,731
Барилга усралтын даатгал	6,282,411	-	6,256,221	24,190	168,465	195,023	30,748	303,769	3,038	15,113	(17,861)	-	290	18,161
Мал амьтдын даатгал	-	8,192	-	(8,192)	-	-	(8,192)	-	-	(1,752)	-	-	(1,752)	-
Автозаврийн хэрэгслийн жолоочийн харууцлагын даатгал	62,346	8,762	6,034	47,549	(10,530)	(25,302)	32,777	-	-	(3,405)	1,532	6,006	4,133	-
Хархицлагын даатгал	2,302,074	198,291	995,083	1,108,689	418,795	41,162	731,056	19,468	10,706	537,278	(491,037)	-	57,047	34,161
Санхүүгийн даатгал	282,733	-	155,484	107,249	12,615	(30,267)	64,366	235,352	16,917	189	-	(1,854)	15,252	42,290
Зөвлөлийн даатгал	-	-	-	-	(1,516)	(825)	590	-	-	8,419	(6,567)	-	1,852	-
Итгэлцлийн даатгал	428	-	-	428	(22)	(22)	298	34,541	10,951	(2)	-	35,697	46,646	-
Жолоочийн харууцлагын даатгал	1,355,793	207,855	383,349	764,590	(842,830)	(467,728)	1,139,693	1,446,835	810,380	(113,432)	58,378	(4,996)	750,329	584,584
2017 оны нийт дүн	22,533,093	1,207,753	11,243,874	10,081,466	1,893,216	(1,145,087)	7,043,163	4,705,634	2,074,468	444,324	(379,999)	242,532	2,381,325	1,203,701

19. Даатгалын гэрээний зардал

мянган төгрөгөөр	2017	2018
Даатгалын зуучлагчийн шимтгэл	1,043,723	1,254,476
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	159,978	61,300
Нийт	1,203,701	1,315,776

20. Давхар даатгалын шимтгэлийн орлого

мянган төгрөгөөр	2017	2018
Факультатив давхар даатгал	151,427	247,482
Гэрээт давхар даатгал	773,965	191,290
Нийт	925,392	438,772

21. Хөрөнгө оруулалтын орлого

мянган төгрөгөөр	2017	2018
Хөрөнгө оруулалтын орлого		
Банк, ББСБ-д байршуулсан хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын орлого	954,770	1,623,255
Үнэт цаасны хүүний орлого болон бусад	272,189	625,121
Нийт	1,226,959	2,248,376

22. Ерөнхий ба удирдлагын зардал

мянган төгрөгөөр	2017	2018
Ажиллагчдын цалингийн зардал	2,019,981	2,439,496
Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	240,296	294,804
Автомашин зардал	59,656	47,215
Ашиглалтын зардал	400	3,915
Бичиг хэрэг, хангамжийн зардал	55,207	69,079
Даатгалын зардал	1,597	3,833
Засвар, үйлчилгээний зардал	8,369	19,977
Мэргэжлийн үйлчилгээний зардал	485,693	341,008
Сургалтын зардал	25,388	15,078

Томилолтын зардал	29,086	15,785
Түрээсийн зардал	188,099	155,583
Уулзалт, арга хэмжээний зардал	249,368	177,563
Шуудан холбооны зардал	157,910	138,718
Элэгдлийн зардал	141,388	125,306
Нийт	3,986,955	3,522,843

23. Борлуулалт маркетингийн зардал

мянган төгрөгөөр	2017	2018
Бизнес уулзалтын зардал	17,158	20,881
Борлуулалтын үеийн идэвхижүүлэлт	17,929	65,119
Маркетинг, сурталчилгааны зардал	174,510	396,536
Харилцагчийн халамжийн зардал	307,694	125,564
Нийт	517,291	608,100

24. Бусад зардал

мянган төгрөгөөр	2017	2018
Найдваргүй авлагын зардал	376,369	544,702
Алданги, торгууль	40,228	6,151
Хандив	-	4,274
Нийт	416,597	555,127

25. Орлогын татварын зардал

мянган төгрөгөөр	2017	2018
Тайлант жилийн татвар	162,548	505,364
Хойшлогдсон татвар	-	-
Нийт	162,548	505,364

Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

мянган төгрөгөөр	2017	Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%)	2018	Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%)
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	1,265,074		4,373,621	
10%-аар татварын хувь хэмжээг тооцсон татвар (2017: 10%)	126,507	10%	437,362	10%
Татвар тооцохгүй хэсэг, цэвэр	(62,647)	-5%	(136,016)	-3%
Хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй түр зөрүү	2,536	0%	(2,961)	0%
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцсон татвар (2017: 10%)	96,152	8%	206,979	5%
Орлогын татварын зардал	162,548	13%	505,364	12%

26. Балансын дараах үйл явдал

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэснээс хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй.

27. Мэргэжлийн шийдэл бүхий нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба үнэлэмж

Тооцоолол болон үнэлэмжийг байнга хийдэг бөгөөд тухайн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл явдлын таамаглал, түүхэн туршлага, бусад хүчин зүйлст үндэслэдэг.

27.1 Мэргэжлийн шийдэл шаардагдах бүртгэлийн тооцоолол

Компани нь ирээдүйн талаарх тооцоолол, таамаглалыг хийдэг.

Нөөц сангийн тооцоолол

“Мандал Даатгал” ХК нь нөөц сан, хохирол нөхөлтийн харьцааг тодорхойлж, учирч болзошгүй эрсдэлээс зайлсхийх зорилгоор СЗХ-ноос зөвшөөрөгдсөн даатгалын нөөц сан байгуулах ангилал болон аргачлалыг ашиглан даатгалын нөөц сангийн хэмжээг тооцдог. Даатгалын нөхөн төлбөрийн нөөц санг Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБНХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц (УБНХНС) гэж ангилна.

Аудитын явцад нөөц сангийн тооцооллыг хөндлөнгийн шинжээч-актуарч давтан тооцоолж, шалгасан

28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл зэрэг байна.

Компани нь арилжааны зорилгоор санхүүгийн хөрөнгийг мөн опцион худалдаалдаггүй байна.

29. Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангахын тулд өөрийн хөрөнгөө удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь гаргасан капитал, нөөц, хуримтлагдсан ашгийг багтаасан эздийн өмчөөс бүрдэнэ.

30. Үүрэг

30.1 Капиталаас хүлээх үүрэг

Компани нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ямар нэгэн томоохон шүүхийн нэхэмжлэл, маргаангүй байна. Тийм учир компани нь холбоотой талтай холбоотой ирээдүйн капиталын зарцуулалтаас хүлээх үүрэг байхгүй.

31. Холбоотой тал

Доор тайлбарласанчлан Компанийн холбоотой талуудад толгой компани, хамтын хяналт, удирдлагатай аж ахуйн нэгжүүд орно.

31.2 Хяналтын харилцаа

Компанийн 40.85%-ийг “Голомт Файнаншил групп” ХХК, 34.15%-ийг “Юу Эм Си Капитал” ХХК, 25.00%-ийг олон нийт эзэмшиж, хянаж байна.

“Голомт Файнэншил Групп” ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хөрөнгө оруулалтын компани юм. Ноён Д. Баясгалан нь тус группийн ихэнх хувийг эзэмшдэг бөгөөд “Мандал даатгал” ХК-д хамгийн дээд хяналт тавигч хувь хүн юм.

31.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд Компани нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн байна.

Холбоотой талуудын нэр, мянган төгрөгөөр	Ажил гүйлгээний төрөл	2017	2018
“Юу Эм Си Альфа” ХХК	Авлага бүртгэв	465	-
“Юу Эм Си Альфа” ХХК	Авлага барагдуулав	1,187	-
“Юу Эм Си Холдинг” ХХК	Авлага бүртгэв	349	-
“Юу Эм Си Холдинг” ХХК	Авлага барагдуулав	349	-
“Эн Пи Си энд Мандал” ХХК	Авлага бүртгэв	-	-
“Эн Пи Си энд Мандал” ХХК	Авлага барагдуулав	1,877	-
“Мандал лайф” ХХК	Авлага, өглөг бүртгэж, барагдуулав	27,673	-
“Мандал лайф” ХХК	Авлага, өглөг бүртгэж, барагдуулав	21,178	-
“Юу Эм Си Капитал” ХХК	Хувьцаа борлуулсан	-	1,515,741

“Голомт банк” ХХК	Даатгал, зуучлан борлуулалт, зуучлагчийн шимтгэлийн дүн	4,565,437	7,307,284
“Голомт секюритиз” ХХК	Даатгал хийлгэв	-	-
“Голомт фاینэншил” ХХК	Даатгал хийлгэв	816	-
“Голомт капитал” ХХК	Даатгал хийлгэв	400	-

31.3 Төлбөрийн чадвар

Компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 150.62% (2017: 109.82%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэсний дагуу зохистой байна.

Мандал Даатгал ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө - 24, Паркглэйс Оффис, 1, 3 давхар
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292, Улаанбаатар 15160

Утас: (976) 7577 3000
Мэдээлэл, лавлагааны төв: (976) 7575 2000
И-мэйл: info@mandal.mn
Вэб хуудас: www.mandal.mn

 facebook.com/mandaldaatgal
 twitter.com/MandalDaatgal

www.mandal.mn

